

ТҮШМЭДИЙН ЗАСАГЛАЛ: ТАЙШИЙН ХҮЧИРХЭГЖИЛТ

П.ДЭЛГЭРЖАРГАЛ

Товч агуулга: XV зууны үеийн Монголын төрийн засаглалд чухал үүрэг гүйцэтгэж байсан Тайшийн талаар монгол сурвалжийн мэдээ харьцангуй бага юм. Монгол сурвалжийн мэдээг хятад сурвалжтай харьцуулах замаар тайшийн институтийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг тодруулах боломжтой. Монголын дотоод улс төрийн тэмцэл гүнзгийрч, их хааны эрх мэдэл суларсан нь түшмэдийн засаглал хүчирхэгжих нөхцөлийг бүрдүүлсэн ажээ. Алтан ургийн легитим эрхтэй хаан болон улс төрийн хүч нөлөө бүхий алтан ургийн бус ноён “тайши”-ийн эрх ашиг хоорондоо нэгдсэнээр “тайшийн институт” бүрэлдэн тогтох нөхцөл бүрдсэн. Монгол улсыг нэгтгэн захирах, бусад ноёдоо захиран барьж байх үүднээс хаан, тайши хоёрын эрх ашиг нэгдмэл байв. Монголын “Их хаан” болон “тайши”-ийн институт нь засаглалын асуудлаар хоорондоо өрсөлдөн тэмцэлддэг ч бие биенээ үгүйсгэх аргагүй, харилцан хамааралтай институт болж төлөвшсөн хэмээн үзэж байна.

Түлхүүр үгс: хаан, тайши, тайшийн институт, түшмэдийн засаглал, легитим эрх

Удиртгал

XV зууны эхэн үеэс тайши тушаалтан ихээхэн эрх мэдэлтэй болж, монголын улс төрд чухал үүрэг гүйцэтгэх болсон билээ. Харин монгол сурвалжид тайши нарын үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл байхгүй. Иймд XV зууны монгол төрийн тайши нарын үйл ажиллагааг тодруулахын тулд хятад сурвалжийн мэдээ баримтыг ашиглах шаардлага тулгардаг.

“Мин улсын магад хууль”¹, “Мин улсын судар”² нь Монгол-Мингийн харилцаа, Монголын хаан болон тайши нарын үйл ажиллагааг судлахад чухал ач холбогдолтой мэдээлэл агуулдаг. Мин улсын магад хуулийн Ойрадын түүхэнд холбогдох мэдээг Шинжааны Ардын хэвлэлийн хорооноос 1982 онд түүвэрлэн хэвлэснийг монгол хэлээр орчуулан “Тод номын гэрэл төв”-өөс хоёр ботиор эрхлэн гаргасан нь чухал ач холбогдолтой юм. Бид өгүүлэлдээ энэхүү орчуулгыг ашиглалаа. Мөн “Мин улсын судар”-ын Уг тэмдэглэл болон Татар,

¹ 明實錄. 中华书局出版, 共183册. 2016

² 明史. 中华书局出版, 1974

Ойрад, Урианхайн бүлэг зэрэг олон шастираас монгол хэл рүү орчуулан МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс гурван ботиор эрхлэн гаргасан нь чухал ач холбогдолтой эрдэм шинжилгээний орчуулга болжээ.³

Түүнчлэн Монголын түүхэнд холбогдох Мингийн үеийн хятад сурвалжуудыг түүвэрлэн 7 ботиор эмхэтгэн Өвөр Монголын их сургуулиас эрхлэн хэвлүүлсэн. Энэхүү эмхэтгэлд Вэй Хуаний “Есөн хязгаарын шинжилгээ”⁴, Е Сянгао-ын “Дөрвөн бүдүүлгийн шинжилгээ”⁵, Жэн Сяо-ын “Умард бүдүүлгийн шинжилгээ”⁶ зэрэг албан бус жижиг сурвалжуудыг эмхэтгэн хэвлэжээ. Эдгээр сурвалжуудад Мин улсын магад хууль зэрэгт байхгүй зарим шинэ мэдээ баримт байдаг. Энэхүү эмхэтгэлд орсон сурвалжуудаас доктор Д.Ундрах “Умарш дайлсан тэмдэглэл”, “Умарш дайлсан хожуу тэмдэглэл”, “Умарш довтолсон тэмдэглэл” гэсэн Юнло хааны Монголыг дайлсан талаарх тэмдэглэл, мөн “Умарш элчилсэн тэмдэглэл”, “Умарш дайлсан хэрэг явдлын тэмдэглэл” гэсэн Инзун хаан монголчуудын олзонд байсантай холбоотой тэмдэглэл зэрэг 6 сурвалжийг орчуулан “Нанхиад сурвалж дахь Монголын түүхэнд холбогдох ойлбор” нэртэйгээр 2020 онд хэвлүүлсэн⁷. Эдгээр сурвалжид Адай, Тогоон, Эсэн тайшийн үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээ буй.

“Ваньлигийн цэргийн гавьяаны тэмдэглэл”, “Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл” зэрэг хятад сурвалжид XV зууны Монголын улс төрийн байдлын талаар тодорхой мэдээ, баримт байдаг. Л.Жамсран, Ваньлигийн цэргийн гавьяаны тэмдэглэл-ийн “Дундад гурван хилийн Монгол ван тайж нарын намтар”-ыг орчуулан, удиртгал, тайлбар хийсэн. Э.Чимэдцэрэн “Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл”-ийн Татарын тухай 7 бүлгийг орчуулан, удиртгал тайлбар хийсэн нь чухал судалгаа болсон⁸.

Мингийн үеийн албан болон албан бус олон хятад сурвалжуудад Монгол, Мингийн харилцааны түүхэнд холбогдох баялаг мэдээ баримт буй. Хятад сурвалжийн эдгээр мэдээ баримтыг монгол сурвалжийн мэдээлэлтэй харьцуулан судлах замаар XV зууны монгол төрийн тайши нарын үйл ажиллагаа, тайшийн институт бүрэлдэн тогтсон үйл явц, хаан болон тайшийн институтийн хоорондын харилцааг судлан тодруулах боломжтой юм.

³ Мин улсын судар. I, II, III боть. Хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг. УБ., 2018

⁴ 魏焕 (Weihuan). 九边考 (Jiubiankao). 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 第一辑. 2006. 238-261 页.

⁵ 叶向高 (Ye Xianggao). 四夷考 (Siyikao). 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 2006. 第二辑. 482-526 页.

⁶ 郑晓 (Zheng Xiao). 皇明北虏考 (Huangming Beilukao). 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 2006. 第一辑. 190-215 页.

⁷ Нанхиад сурвалж дахь монголын түүхэнд холбогдох ойлбор. Хятад хэлнээс орчуулж, удиртгал, тайлбар бичсэн Д.Ундрах. УБ., 2020

⁸ Цю Цзюсы. Ваньлигийн цэргийн гавьяаны тэмдэглэл. *Дундад гурван хилийн Монгол ван тайж нарын намтар*. Орчуулсан Л.Жамсран. УБ., 2011; Янь Цунцзянь. Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл. XVI-XXII дэвтэр. Орчуулсан Э.Чимэдцэрэн. УБ., 2024

XV зууны монголын улс төрийн түүхийг судалсан судлаачид тайши байсан төрийн зүтгэлтнүүдийн түүхийг ямар нэгэн байдлаар судалж зохиол бүтээлдээ тусгасаар ирсэн. Ялангуяа Тогоон, Аругтай, Эсэн тайшийн намтар, үйл ажиллагаа нэлээд сайн судлагдсан. Харин тайшийн тушаал нь төрийн институт болсон үйл явц, түүхэнд гүйцэтгэсэн үүргийнх талаас судалсан судалгаа харьцангуй бага юм.

Хэнри Сэрри (Henry Serruys), Л.Мөнх-Эрдэнэ нар тайшийн тушаалыг институт болсон талаар, XV зууны монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаас нь тусгайлан судалжээ. Хэнри Сэрри Мин улсын магад хууль зэрэг хятад сурвалжийн мэдээнд тулгуурлан тайши нь XV зууны Монголын төрийн чухал албан тушаал байж, зарим үед хаанаас илүү эрх мэдэлтэй байсныг судлан тогтоосон билээ⁹. Харин Л.Мөнх-Эрдэнэ “тайшийн засаглалаас тайжийн засаглалд” шилжсэн үйл явцыг судлах явцдаа тайшийн засаглалын асуудлыг нарийвчлан судалсан байна. Тэрээр “Тайши хэдийгээр армийг захирч байсан ч тэрээр зүгээр нэг цэргийн жанжин байсангүй; тэр хаант улсын үр дүнтэй захирагч байсан. Энэ утгаараа түүний засаглал Японы шогунтай тун төстэй харагдаж байна. Гэсэн хэдий ч тэр албан тушаалаас ялгаатай нь тайш хэзээ ч хаант улсын удам дамжсан захирагч байгаагүй: тэрээр өөрийн түмний угсаа залгамжилсан ноён (ноуан) байсан ч тайшийн хувьд тэрээр томилогдсон түшмэл байв. Ийнхүү орчин цагийн хэллэгээр тайши нь хаант улсын ерөнхий сайд байв”¹⁰ гэсэн дүгнэлтэд хийжээ. Гэвч эдгээр судлаачид яагаад тайши нь Монгол төрийн тэргүүлэх албан тушаал болсны шалтгаан нөхцөл, хаан болон тайшийн институтийн хоорондын харилцааны асуудалд төдийлөн анхаарал хандуулсангүй.

Тиймээс XV зууны тайшийн үйл ажиллагааг тодруулах замаар тайшийн институт бүрэлдэн тогтсон үйл явц, улс төрийн нөхцөл байдал, тайши болон хааны институтийн хоорондын харилцааг судлан тодруулах нь чухал ач холбогдолтой.

Сүр хүчин бууран доройтож Монгол даяар засаглалаа хэрэгжүүлэх хүч нөлөөгүй болсон “алтан ураг”-ийн хаан, нөгөө талаас цэрэг, улс төрийн хүч нөлөөтэй ч улс орныг засаглах легитим эрхгүй алтан ургийн бус ноён хоёрын эрх ашгийн нэгдэл нь “тайши”-ийн институт бүрэлдэн тогтох нөхцөлийг бүрдүүлжээ. Их хааны зарлигаар томилогдож байж тайшийн эрх мэдлийн легитим шинж баталгааждаг байсан нь хоорондоо өрсөлддөг ч, харилцан хамааралтай хоёр институт зэрэгцэн оршиж, засаглалаа хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байсан хэмээн үзэж байна.

Тайшийн албан тушаалын уламжлал

XV зууны үеийн Монголын төрийн засаглалд “тайши”-ийн институт чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Тайши нь монголчуудын уламжлалт цол юм. Тайши цолыг Хятан гүрнээс монголчууд авч хэрэглэсэн. Хар Хятан улсыг үндэслэн байгуулагч

⁹ Henry Serruys. The Office of Tayishi in Mongolia in the Fifteenth Century. *Harvard Journal of Asiatic Studies*, Vol. 37, № 2 (Dec., 1977). pp. 353-380.

¹⁰ Munkh-Erdene L. *The Taiji Government and the Rise of the Warrior State: The Formation of the Qing Imperial Constitution*. Brill, Leiden. p. 165

Елюй Даши-ийн “даши” нь хүний нэр биш, “*тайши*” гэсэн албан тушаалын нэр бөгөөд Елюй *тайши* гэсэн үг хэмээх саналыг гүнзгийрүүлэн судлууштай юм.

Хятан гүрний нөлөөнөөс гарсан Хамаг Монгол улс тайши цолыг хэрэглэж байсан нь сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Монголын нууц товчоонд “Хадаан *тайши*”, “Нэгүн *тайши*” гэж тэмдэглэсэн¹¹ бол, Судрын чуулганд “Нэгүн *тайши*”, Саган Сэцэний Эрдэнийн товчид “...түүний хөвгүүн нь Хабул хаан, түүний хөвгүүн нь Бартам баатар, түүний хөвгүүн Есүхэй баатар, Нэгүн *тайши*, Мэнгэгү сэцэн, Даридай отчигин дөрөв буюу” хэмээжээ¹². Сурвалжийн дээрх мэдээнээс үзэхэд, XI-XII зууны үед Хамаг Монгол улсад *тайши* цол байсан нь тодорхой юм. *Тайши* нь Хамаг Монголын бүх цэргийн хэргийг мэддэг тушаал байсан гэж судлаачид үздэг бөгөөд “Хадаан *тайшийн* эрх мэдэл Хотула хаанаас дээгүүр шахам байж, цэрэг дайн зарлах, болиулах бүх эрх Хадаан *тайшийн* гарт байжээ”¹³ хэмээн бичсэн нь буй. Ямар ч гэсэн Их Монгол улс байгуулагдахаас өмнөх үед хааны дараа орох эрх мэдэл бүхий албан тушаалтан нь *тайши* байсан нь тодорхой байна.

Их Монгол улс байгуулагдаж, Чингис хаан төр, засаг захиргааны иж бүрэн шинэтгэл хийхдээ “*тайши*” тушаалтныг томилсонгүй. Гэхдээ Чингис хаан төр байгуулахдаа алтан ургийн болон түшмэдийн засаглал гэсэн зэрэгцээ бүтцийг буй болгосон байна. Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдлийг хааны засаглал буюу “алтан ургийн засаглал”, түшмэдийн засаглал гэсэн хоёр хэсэгт хуваасан гэж үзэж болно. Тиймээс 1206 онд Чингис хаан 95 мянгатын ноёдыг томилохдоо алтан ургийн бус ноёдоос бүрдүүлжээ. Харин ээж, дүү, хөвгүүн нартаа газар нутаг, иргэдийг өмч болгон шагнасан байна.

Гэхдээ Юань улсын судрын 110 дугаар бүлгийн “Турван гүнгийн илтгэл нэгдүгээр”-т Бээжинд сууж умард Хятадын асуудлыг хариуцаж байсан Мухалайг 1217-1223 онд *тайши* цолтой байсан гэжээ. Юань улсын судрын мэдээг үндэслэвэл, Их Монгол улс байгуулагдсанаас хойших хамгийн анх “*тайши*”-аар өргөмжлөгдсөн хүн нь Мухалай болж таарч байна. Монголын нууц товчоонд Мухалайг “улсын ван” цолтой байсан гэдэг.

Чингис хаан нас барахаасаа өмнө хаан ширээг Өгэдэйд залгамжлуулахаар шийдсэнээс гадна эзэнт гүрний баруун гарыг Зүчи, Цагадай нарт, эзэнт гүрний зүүн гарыг Хасар, Хачиун, Тэмүгэ отчингин нарт захируулах шийдвэр гаргасан байдаг. Төрөлх Монгол нутаг буюу “голын улс”-ыг Тулуйд өгсөн хэмээн судлаачид үзсээр ирсэн. Гэтэл үнэн хэрэгтээ “голын улс”-ыг баруун зүүн гарт хувааж, зүүн гарыг Тулуйд, баруун гарыг Өгэдэйд захируулсан гэсэн сонирхолтой саналыг Л.Мөнх-Эрдэнэ дэвшүүлсэн байдаг. Монголын нууц товчооны мэдээгээр, Өгэдэй хааны үед баруун тийш хийсэн аян дайны “голын улс”-ын цэргийг Гүюг захирч Хархорумаас хөдөлснөөс харахад энэ санал үндэслэлтэй байж болох юм.

¹¹ Монголын нууц товчоон. §53, § 56

¹² Саган Сэцэн. *Эрдэнийн товч*. Хөрвүүлэг тайлбар хийсэн М.Баярсайхан. УБ: Соёмбо хэвлэлийн газар, 2005

¹³ Далай Ч. *Хамаг Монгол улс* (1101-1206). УБ., 1996. т. 53.

Өгэдэй хаан Чингис хааны төр байгуулахдаа баримталсан зарчмыг тууштай хэрэгжүүлж, эзэнт гүрний харьяа бүс нутгуудыг хааны нэрийн өмнөөс хариуцан захирч байх захирагчийн газруудыг байгуулсан байдаг. Захирагч, даругачи нар нь эзэнт гүрний харьяа бүс нутгуудад хүн ам, тариалангийн талбайн тооллого явуулж, түүнд үндэслэн тогтоосон татварыг авч, хааны санд нийлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байв. Түүнчлэн хан хөвгүүдийг эзэмшил нутагтаа дураараа татвар хураах, зарлиг тушаал гаргах, цэргийн дайчилгаа явуулахыг хязгаарлаж байжээ.

Юань улсын судрын 110 дугаар бүлэг “Гурван гүнгийн илтгэл”-д:

“Юань улсын эхэн үед Тайши, Тайбо, Тайбао-г гурван гүн болгож, Мухалай улсын вангаас эхлэн *тайши* тавьж, хожим гурван гүнг цөмийг томилдог” болсныг дурдаад тодорхой мэдэж чадаагүй боловч Мухалайгаас хойш гурван гүнгээр томилогдсон хүмүүсээр гурван гүнгийн илтгэлийг бичив¹⁴ хэмээжээ. Юань улсын судрын 110 дугаар бүлгийн “Гурван гүнгийн илтгэл нэгдүгээр”-т Чингис хаанаас Тугтөмөр хааны үед гурван гүн хэмээх Тайши, Тайбо, Тайбао цолоор өргөмжлөгдсөн хүмүүсийг бичсэн. Харин Тогоонтөмөр хааны үед гурван гүнгээр өргөмжлөгдсөн хүмүүсийг “Гурван гүнгийн илтгэлийн хоёрдугаар” хэсэгт тусад нь тэмдэглэжээ.

Чингис хааны үед 1217-1223 онд Мухалай тайши байсан бөгөөд Өгэдэй хаан ширээнд өргөмжлөгдөөд 1229 онд Ахайг *тайши*, Тухуйг *тайбо*, Мин-ань-г *тайбао* өргөмжилсөн боловч тэдний тухай тодорхой мэдээ байхгүй тул тодруулах боломжгүй байгааг “Гурван гүнгийн илтгэл”-д тэмдэглэсэн байдаг. Харин Хубилай хааны үед тайши өргөмжилсөнгүй, Лю Бинжуныг 1264 онд *тайбао* болгожээ. Юань улсын Төмөр хаан 1300 онд Учичарыг анх *тайшиар* томилсон байна. Юань улсын сударт тэмдэглэгдсэн *тайши* цолтой хүмүүсийг хүснэгтээр үзүүлбэл:

	Хааны нэр	Тайшиар өргөмжлөгдсөн оны цол	Тайшийн нэр	Тайши байсан онууд
1	Төмөр хаан	Юань жэний IV он, 1300	Учичар	1300-1303
2	Хайсан хаан	Жида-ын III он, 1310	Алагбуха	1310
3		Жида-ын III он, 1310	Турчихан/түржигэн	1310-1311
4	Аюурыархвад	Хуан чин-ийн I он, 1312	Асахан	1312-1315
5		Вань юү-ийн III он, 1316	Тэмүдэр	1316-1320
6	Содбал хаан	Жижи-ийн I он, 2321	Тэмүдэр	1321-1322
7	Есөнтөмөр	Тай диний I он, 1324	Байху	1324
8		Тай диний II он, 1325	Алтачу	1325
9	Тугтөмөр	Тянь ли-ийн I он, 1328	Элтөмөр	1328-1331

¹⁴ Юань улсын судар. 110 дугаар бүлэг: Гурван гүнгийн илтгэл. *Юань улсын судар. 106-113 дугаар боть*. Хятад хэлнээс орчуулж, оршил тайлбар бичсэн Д.Идэр. УБ., 2017. т. 57

10	Тогоонтөмөр	Юань туны I он, 1333	Элтөмөр	1333
11		Юань туны I он, 1333	Баян	1333-1340
12		Жи юаний VI он, 1340	Мажартай	1340-1347
13		Жи жэний XII он, 1352	Тогтох	1345-1354
14		Жи жэний XV он, 1355	Ван Жяну	1355-1363
15		Жи жэний XXV он, 1365	Байсар	1365-1366

Эх сурвалж: Юань улсын судрын 110-р бүлэг, “Гурван гүнгийн илтгэл”

Юань улсын судрын мэдээнээс үзвэл, XIV зууны эхэн үеэс Юань улсад тайши цолтныг тогтмол өргөмжлөх болсон байна. Түүнчлэн Арван буянт номын цагаан түүх (Цагаан түүх)-т “дөрвөн тайши” гэж олонтоо тэмдэглэжээ. Юань улсын үеийн төрийн хэрэг явдалтай холбогдуулан бичихдээ:

“Түүгээр гурван их үйлийг гурван *хонжин* мэд

Дөрвөн их төрийг дөрвөн *тайши* мэд

Долоон их бинг долоон *зайсан* мэд

Есөн их бэлгийг есөн *өрлөг* мэд

Таван өнгө дөрвөн харь улсад аравтын ах тавьт, зуут, мянгат, түмтэн, түг түмний ноёд нь аймаг аймаг улсаа тус бүр мэдтүгэй” хэмээжээ.

Цагаан түүхэнд “дөрвөн их төр” гэдгийг:

“Нэгдүгээр их хөлгөний ёсон амгалан төр

Хоёрдугаар хааны барих энх төр

Гуравдугаар нууц хөлгөний ёсон жиха (бэлгэ билгийн) төр

Дөрөвдүгээр түшмэдийн барих дайчин төр”¹⁵ хэмээнээс үзэхэд “тайши” нь шашин төрийг хослон барих хос ёсны үзэл онолд нэвтэрсэн, төрийн томоохон зүтгэлтний үүргийг гүйцэтгэж байсан ажээ.

Лу. Алтан товчид “суут богд Чингис хаан Бөртгөлжин нэрт хатнаа авахуйд ер есөн *өрлөг*, таван *тайши*, таван өнгө, дөрвөн харь улс хурааж, хуран суухуйд”¹⁶ хэмээн “таван *тайши*” хэмээжээ. Сурвалжийн дээрх мэдээнээс үзэхэд, *тайши* нь төрийн чухал албан тушаал байсан нь тодорхой боловч дөрөв, эсвэл таван *тайши* нэгэн зэрэг байсан гэсэн санаа бус, харин эдгээр тоо нь хэлц маягаар хэрэглэгдсэн гэж үзэх нь зүйтэй болов уу. Энэ нь “есөн *өрлөг*” гэдэг хэлцтэй адилхан бөгөөд хааны дэргэд *өрлөг* сайд нар байсан гэдгийг илэрхийлэх боловч заавал есөн *өрлөг* сайд байсан гэсэн утгыг илтгэхгүй юм. Монгол сурвалжуудад ийнхүү *тайши* нь төрийн чухал албан тушаал байсныг илтгэн харуулсан баримт олон буй.

Харин XV зууны үед тайши цолтон ихээхэн хүчирхэгжиж, түшмэдийн засаглалын тэргүүлэх институт болон бэхэжжээ.

¹⁵ Арван буянт номын цагаан түүх. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Ш.Чоймаа, Б.Батбаяр. УБ., 2015. т. 58-59.

¹⁶ Лувсанданзан. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2015. т. 158

Тайши тэргүүлэх албан тушаал болсон нь

XV зууны эхнээс 1480 хэдэн он хүртэлх 80 орчим жилд монголын төрийн хамгийн хүчирхэг албан тушаал нь тайши байв. 1206 онд Чингис хаан Монголын төрийг байгуулахдаа “алтан ураг”-ийн болон түшмэдийн засаглалын тогтолцоог буй болгосон. Тиймээс Чингис хаан алтан ургаас түшмэл томилоогүй билээ. Төрийн засаглалын тогтолцооны энэхүү зарчим Их Юань улсын үед уламжлан хэрэгжсэн гэж үзэж болно. Юань улсын сүүлийн жилүүдэд түшмэлийн засаглал улам бүр хүчтэй болсоор байсан ажээ. Хятад дахь монголчуудын ноёрхол унаж, хааны засаглал Хархорумаар төвлөрөх болоход Монгол нутагт Аригбөхийн удам болон алтан ургийн бус харачу ноёд ихээхэн хүч нөлөөтэй байжээ. Тэд эхэн үедээ их хааны засаглалыг хүлээн зөвшөөрч байсан ч яваандаа хааны сүр хүч бууран доройтохын хэрээр түүнд захирагдахгүй бие даахыг эрмэлзэх болов. Монголын их хааны цэрэг, улс төрийн хүч нөлөө бууран доройтохын хэрээр ноёд, түшмэдийн нөлөө ихсэн хүчирхэгжих болсон. Түшмэлийн засаглал дотор тайшийн институт бүрэлдэн тогтож, Монгол төрийн засаглалын гол хүч болсон нь XV зууны эхэн үед холбогдоно. Тиймээс тайшийн тушаалд алтан ургийн биш хүн томилогддог байсан. Түшмэлийн засаглал нь хааны засаглалыг бэхжүүлэхэд туслах үүрэгтэй байсан ч хүчний харьцаанаас хамаарч төрийн гол эрх мэдлийг “тайши” хэрэгжүүлэх явдал байжээ. Яваандаа монголын хамгийн хүчирхэг түмний ноён нь тайшиар томилогдох болсон.

Алтан ургийн бус хүчирхэг ноён нь өөрөө хаан болох легитим эрхгүй тул “тайши” болж, хаантайгаа нийлэн монголыг нэгтгэхийг оролдож байсан хэрэг юм. Монгол нутагт засаглалаа бүрэн хэрэгжүүлэх, бусад ноёдоо захиран барьж байх үүднээс хаан, тайши хоёрын эрх ашиг нэгдмэл байсан.

Юань гүрний дараа *тайшийн* тушаал хэрхэн төрийн тэргүүлэх албан тушаал болсон болон тухайн үеийн нийгэм-улс төрийн түүхийг ойлгохын тулд *тайши* албан тушаалтны улс төрийн үйл ажиллагааг судлан шинжлэх нь чухал ач холбогдолтой юм.

Мархачи тайши. Монгол сурвалжид анх тэмдэглэгдсэн Юань гүрний дараах үеийн хамгийн алдартай *тайши* бол Аругтай юм. Мингийн үеийн хятад сурвалжид Аругтайгаас өмнө Мархачи (馬兒哈咱 *ma'erhazan*) нь *тайши* цолтой байсныг тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр монгол сурвалжид түүний тухай мэдээ байхгүй боловч “Мин улсын магад хууль”-д Мархачи нь 1388 онд *тайвэй*, 1403 онд *тайши*, мөн баруун гарын *чинсан*, хожим *тайши* цолтойгоор хэд хэдэн удаа тэмдэглэгдсэн¹⁷.

1406 оны 10 сард Урианхай яваад ирсэн элч “дайсны толгой Есүнтэй харьяат хүмүүстээ алуулж, Мархачи Ойрадад дагаар орж, Аругтай Хайлаар голын сав газарт нутагласныг хэлэв”¹⁸ хэмээнэс үзэхэд Гүйличи хаан Ойрадтай хийсэн дайнд үндсэндээ ялагдаж, Зүүн Монголын Мархачи (馬兒哈咱 *ma'erhazan*) ноён

¹⁷ Serruys, H. The Office of Tayisi in Mongolia in the Fifteenth Century. Harvard Journal of Asiatic Studies, Vol. 37, №2(Dec., 1977), p. 358.

¹⁸ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizong shilu). Юнло-ийн 4-р оны 10 сарын хөхөгчин туулай өдөр.

Ойрадад дагаар ороход хүрч, Аругтай ноён зүүнш шилжин суусан нь тодорхой байна. Гэвч 1409 онд Мархачи нь Буньяшир хааныг дэмжихээр зүүн Монголд буцаж иржээ. Түүний нэр хамгийн сүүлд 1413 онд хятад сурвалжид тэмдэглэгдсэн болохыг Хэнри Серрис судлан тогтоосон байдаг. Энэ үед тайши нь түшмэлийн том тушаал байсан нь тодорхой боловч тайшийн институт бүрэлдэн төлөвшөөгүй байсан үе юм. Мархачийн хашиж байсан тайшийн албанд Аругтай томилогджээ.

Аругтай тайши (1408-1434 он). Тайшийн институт бүрэлдэн төлөвшихөд гол нөлөө үзүүлсэн хүн бол Аругтай тайши юм. XV зууны эхэн үед Аругтай нь зүүн Монголын хамгийн хүчирхэг удирдагч, гол нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн байв. Хэнийг хаан суулгахыг тэрээр шийдэж байсан төдийгүй Мин улстай нэгэн үе дайсагнаж, нэгэн үе найрсаг харилцаатай тогтоож байсан нь нэлээд сонирхолтой. Эрдэнийн товчид өгүүлснээр, Ойрадын Үгэчи хашха нь Элбэг хааныг егүүтгэн Өлзийт хатныг нь аваад, “Элзийт гоо бэйж бээр жирэмсэн нь ... Үгэчи хашха-г авахуйд долоон сартай одож, гурван сар болоод цагаан луу жилээ нэгэн нуган төрснийг Ачай хэмээн нэрийдэж, Үгэчи хашха хөвгүүнчлэн асарч, Асудын Өөдлөх нэртгийг Батула чинсан бээр араг үүргэн аргал түүлгэж Аругтай хэмээн нэрийдэн зарж явжээ”¹⁹. Сурвалжийн дээрх мэдээг баримталбал, Аругтай гэдэг түүний хоч, жинхэнэ нэр нь Өөдлөх бөгөөд Асуд аймгаас гаралтай хүн юм. Монгол сурвалжийн дээрх мэдээ нь хятад сурвалжийн мэдээ болон түүхэн үйл явдлуудтай тохирохгүй байна. Нөгөө талаар Монгол сурвалжид Аругтайн үйл ажиллагааны талаар мэдээ харьцангуй бага тэмдэглэгдсэн байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Хятад сурвалжийн мэдээг баримталбал, 1402 онд Өгэдэйн угсааны Гүйличи нь Аругтайн дэмжлэгээр хаан болсон ажээ. Гүйличи хаан Аругтай, Алулгөмөр, Найрбуха нарыг түшиглэн улс орноо нэгтгэж, дайн самууныг эцэс болгохыг оролдсон тухай Ваньли хааны цэргийн гавьяаны тэмдэглэлд:

“Түүнээс хойш удалгүй Гүнтөмөр нас барж, Гүйличи их ор суув. Гүйличи Юань улсын их хаадын удмын хүн биш юм. Шуньди (Тогоонтөмөр) хаанаас Гүйличи хүртэл долоон үе өнгөрсөн ажээ. Учир иймд түүний харьяат нарын олонх нь урвав. Гүйличи *тайбао* Аругтай, *Жыюань* Алулгөмөр, *тайвэй* Найрбуха нарыг түшиглэн харьяат нараа түвшитгөж, самууныг эцэс болгов. ... Тэр жил бол Зянь вэний гуравдугаар (1401) он юм. Дараа жил нь Юнло хуанди залгамжлав”²⁰ хэмээсэн байдаг.

Харин “Мин улсын магад хууль”-д 1403 онд Мархачийн хамт Аругтай *тайбао* цолтой анх тэмдэглэгдсэнээс хойш уг сурвалжид байнга дурдагдаж байгаа нь зүүн монголын нөлөөтэй язгууртан байсны гэрч болно. Мин улсын хаанаар Юнло өргөмжлөгдөөд, 1403 онд Монгол улсын хаан Гүйличи (鬼力赤 *guilichi*)-д ухаалан сэнхрүүлэх захидал илгээхдээ “түүний жыюань (知院 *zhiyuan*) Аругтай (阿魯台 *alutai*), чинсан (丞相 *chengxiang*) Мархачи (馬

¹⁹ Саган Сэцэн. *Эрдэнийн товч*. Хөрвүүлэг тайлбар хийсэн М.Баярсайхан. УБ., 2015.т. 162.

²⁰ Цю Цзюсы. Ваньлигийн цэргийн гавьяаны тэмдэглэл. *Дундад гурван хилийн Монгол ван тайж нарын намтар*. Орчуулсан Л.Жамсран. УБ., 2011. т. 18.

兒哈咱 ma'erhazan) нарыг бас шагнасан”²¹ гэжээ. Ийнхүү Мин улсын сударт Аругтай нь жыюань цолтойгаар анх дурдагддаг. Энэ үеэс хойш Аругтайн нэр хятад сурвалжид байнга тэмдэглэгдэх болсон. Мин улсын Юнло хааны захидалд Гүйличи хаан хариу өгсөнгүй, харин Мин улсын элчийг барьж хорьсноор Монгол Мингийн харилцаа хурцаджээ.

Харин энэ үед Гүйличи хаан, Аругтай нар Ойрадтай дайсагналцаж, харилцан байлдах болжээ. Удалгүй Гүйличи хаан Аругтай нар эвдрэлцэн дайсагнаж, Аругтай нь Гүйличийг хороон, Гүнтөмөр хааны дүү Буньяаширийг дэмжин 1408 онд хаан болгосон ажээ. Хятад сурвалжуудад “Түүнээс хойш, Аругтай Гүйличийг хороож, улмаар Юаний хойчис болох Буньяашир (本雅失里 benyashili)-ийг Бэшбалык (別失八里 beishibali)-аас угтаж, хаан (可汗 kehan) өргөмжлөв”, “Зургаан онд Аругтай Монголын их хааны удмын хүн Буньяаширыг урьж ирүүлэв. Гүйличиг алаад түүнийг их ор суулгав”²² гэх мэтээр тэмдэглэжээ. Харь улс орны тухай бүрэн тэмдэглэлийн Татарын бүлэгт “Урьд Монголын хаан Гүнтөмөрийг алагдсаны дараа Гүйличи хаан суусан бөгөөд тэр нь Чингисийн удмын хүн биш байсан учир мөн доод хүмүүстээ алагджээ. Тэгээд Аругтай тайши болж улсыг захирч байсан ба одоо Буньяашир хаан ширээг залгамжлан суужээ”²³ хэмээн Аругтайг тайши хэмээн тэмдэглэсэн байдаг. Чухам Буньяашир хаан ширээнд суухад Аругтай хамгийн гол үүргийг гүйцэтгэсэн нь тодорхой юм. Тиймээс 1408 онд Буньяашир хааны зарлигаар Аругтай тайшийн тушаалд томилогдсон гэж үзэж болох юм.

1409 онд Мин улсын Юнло хаан 10 түмэн цэргийн хүчээр Буньяашир, Аругтай нарыг дайлуулсан. Буньяашир хаан Ойрадын довтолгоонд өртөн, Аругтайтай хамт Лүяю гол руу шилжин сууж байхад нь Мин улсын цэрэг довтолсон боловч томоохон ялагдал хүлээн таван жанжин бүгд амь үрэгджээ. Ийнхүү Буньяашир хаан, Аругтай нар чухал ялалт байгуулсан байдаг.

Дараа жил нь буюу 1410 онд Юнло хаан өөрөө 50 түмэн цэрэг авч Монгол улсыг довтолжээ. Энэ бол Юнло хааны өөрөө цэрэг удирдан Монгол улс руу хийсэн анхны довтолгоо бөгөөд нийт таван удаа өөрийн биеэр удирдан үлэмж их цэргийн хүчээр Монголд довтолсны олонх нь Аругтайтай хийсэн байлдаан юм. Мин улсын их цэрэг ирж яваа мэдээ аваад, Буньяашир хаан баруун зүгт, Аругтай зүүн тийш мөр буруулан зайлсхийжээ. Буньяашир хаан болон Аругтайн цэрэг тус тусдаа Мин улсын цэрэгтэй тулгаран байлдаад аль аль нь ялагдан зугтсан байна. Мингийн цэрэг араас нь нэлээд хөөсний эцэст буцжээ. “Өвөл нь Аругтай элч мориор алба барихаар (貢馬 gongma) ирэхэд, хуанди хүлээн авав”²⁴ хэмээн Мин улсын судар мэдээлдэг. Аругтай Мин улстай харилцаагаа сайжруулж, хэд хэдэн удаа элч илгээсэн байдаг. 1412 онд Ойрадын Батула (хятад сурвалжид

²¹ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8467 頁.

²² 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8467 頁; Цю Цзюсы. Ваньлигийн цэргийн гавьяаны тэмдэглэл. *Дундад гурван хилийн Монгол ван тайж нарын намтар*. Орчуулсан Л.Жамсран. УБ., 2011. т. 18.

²³ Янь Цунцзянь. Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл. XVI-XXII дэвтэр. Орчуулсан Э.Чимэдцэрэн. УБ., 2024. т. 44.

²⁴ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8468 頁.

Махаму хэмээдэг) нь Буньяашир хааныг алаад, Дэлбэгийг хаанаар өргөмжилжээ. Аругтай Мин улсад элч илгээн “Махаму (馬哈木 mahamu, Батула) нар өөрийн эзнийг хороож, бас дураараа Дэлбэг (答里巴 daliba)-ийг хаан болгосон тул ... хуучин эзнийхээ өшөөг авч өгөхийг гуйжээ”. Мин улсын хуанди энэхүү саналыг дуртайяа хүлээн авч, Аругтайг Хархорумын ван (和寧王 henin wang) өргөмжилсөн²⁵. 1414 онд Юнло хаан өөрийн биеэр их цэргээ удирдан Ойрадыг довтлон ялалт байгуулжээ. Аругтай 1416 онд Ойрадыг дотолж ялсан байдаг. Гэвч Аругтай болон Мингийн найрсаг харилцаа удаан үргэлжилсэнгүй. 1421 оноос Мин улстай дайсагнах болж, улмаар Мин улсын хил хязгаарт халдах болсон тул Юнло хаан 1422 онд дахин өөрийн биеэр цэрэг удирдан Аругтайг дайлсан ажээ. Хөлөн нуурт нутаглаж байсан Аругтай Мингийн их цэрэг ирж буй мэдээ аваад даруй умар зүгт зайлан нүүв. Мингийн цэрэг үлдсэн адуу мал, зэр зэвсгийг олзлон аваад, ялалт байгуулсан дүр үзүүлэн буцсан ажээ. Аругтай Мингийн хил хязгаарт халдах болсон тул 1423 онд Юнло хаан цэргээ удирдан умард зүг довтолсон боловч Аругтай аль хэдийн зайлан одсон тул Мингийн цэрэг аргагүйн эрхэнд буцжээ. Аругтай дахин хил хязгаарыг довтолон үймүүлэх болсонд 1424 онд Юнло хаан цэргээ удирдан умард зүг их цэргийн хүчээр довтолсон боловч Аругтай мөн хол зайлан одсоныг олж мэдээд Юнло цэргээ эргүүлэн татахаас аргагүй болсон. Буцаж явах замдаа Юнло хаан нас барснаар энэ хоёр хүмүүний хоорондын өрсөлдөөн, дайсагналцал эцэс болжээ. Юнло хааны таван удаагийн Монгол улс руу хийсэн аян дайн нь Мин улсын санхүүд ихээхэн дарамт учруулж, хааны санг хоослоход хүрсэн боловч, монголчуудыг цэрэг улс төрийн хүчийг устгах төлөвлөгөөгөө биелүүлж чадаагүй. Иймээс Юнло-ын дараа үеэс Мин улс цэргийн хүчээр нүүдэлчдийг дарах түрэмгий бодлогоосоо аажмаар татгалзаж, худалдааны хориг тавих, хориглон хамгаалах бодлого хэрэгжүүлж эхэлсэн.

Монголын төрийн эрх мэдлийг өөрийн гарт атгаж, Монголыг нэгтгэхийн төлөөх Аругтай тайшийн тэмцлийн гол өрсөлдөгч нь Ойрадын Тогоон байв. Адай хаан, Аругтай тайши нар Ойрадын Тогоон тэргүүтэй ноёдын эсрэг удаа дараа дайтан, ялж, ялагдаж байсан. Энэ тэмцэл эцэстээ Аругтайн ялагдлаар төгссөн байдаг.

1431 оны 2 сард дагаар орсон монголчуудын мэдүүлснийг Мин улсын магад хуульд тэмдэглэсээр:

“Аругтай Ойрадын Тогоон нар харилцан дайтаж, Аругтай ялагдан ухарч, аймаг олон нь бутран сарниж, олонх нь хилийн ойролцоо байх бөгөөд тэдний дотор дагаар ирэхийг хүсэгчид байна” хэмээжээ.

Мөн түүнчлэн Аругтайн харьяат Тогтох нар дагаар ороод “Аругтай Ойрадад шахагдаад гэр орон, харьяат хүмүүсээ дагуулан өмнөш явсан” хэмээсэн нь дээрх мэдээ үнэн болохыг давхар нотолдог²⁶. Энэ удаагийн тулалдаанд Аругтай үлэмж их хохирол амсан, дахин сэргэхгүйгээр ялагдсан бололтой.

²⁵ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8468 頁.

²⁶ 明實錄 (Ming shilu). 宣宗實錄 (Xuanzong shilu). Сюаньдэ-ийн 6-р оны 2 сарын улаан бич өдөр; Сюаньдэ-ийн 6-р оны 4 сарын шаргачин хонь өдөр.

1434 оны 4 сард Аругтай нь Мин улсын хаанд элч илгээн Ойрадад ялагдан, өөрийн биеэ аван зугтан гарсан тухай өгүүлэхдээ “Эцэг хүү, ах дүү бие биенээ хайхрахаа болив” хэмээжээ. Энэ нь Аругтай бүрэн ялагдаж, нөхцөл байдал хүнд байсныг илтгэж байна. Удалгүй 1434 оны 8 сард Мин улсад дагаар ирсэн монголчууд “Аругтай нэгэнт нөхцөж, түүний хүү болон харьяат олон нь бүгд бутран сарниж” эдүгээ Монголын зүүн өмнөд хэсэгт байгаа талаар мэдээлжээ. Түүнчлэн Мин улсын хаан “Өдгөө дагаар ирэгчид бүгд Аругтай нэгэнт Ойрадад хорлогдож, харьяат аймаг нь бутран сарнисан хэмээн ярьж байна. ... Ойрадын Тогоон нэгэнт Аругтайг алсан бол эрхгүй санаандаа хүрч, хил орчмоор өнгөлзөх нь тодорхой. ...Болгоомжлогтун” гэсэн зарлиг гаргаж²⁷ хилийн хамгаалалтыг чангатгахыг тушаасан байдаг. Мин улсын магад хуульд Аругтай, Тогоон нарын олон жил үргэлжилсэн тэмцэлд Тогоон ялж, Аругтай алагдсан тухай тодорхой мэдээлдэг.

Гүйлчийг хаан өргөмжилсөн 1402 оноос 1434 онд алагдах хүртэлх Монголд улс төрийн хямрал ид өрнөж, Мин улсын довтолгоо эрчимжсэн хүнд хэцүү цаг үед Аругтай нь зүүн Монголын хамгийн хүчирхэг, нөлөө бүхий төрийн зүтгэлтэн байв. Алтан ургийн хэд хэдэн язгууртныг хаан өргөмжилж, өөрөө тайши нь болж, Мин улстай олон удаа дайтаж, найрамдаж явжээ. Монгол улсад тайшийн хүчирхэг институт бүрэлдэн тогтоход гол үүрэг гүйцэтгэсэн төрийн зүтгэлтэн нь Аругтай юм. Аругтай тайшийн үед тайшийн институт бүрэлдэн тогтсон нь түшмэдийн засаглал хүчирхэгжихэд чухал нөлөө үзүүлсэн хэмээн үзэж болно.

Монгол сурвалж дахь Аругтайн тухай мэдээ заримдаа нэлээд зөрчилтэй. Тухайлбал, Эрдэнийн товчид өгүүлснээр, Өлзийт гоо бэйжээс төрсөн хүүг “Ажай хэмээн нэрийдэн Үгэчи хашха хөвгүүнчлэн асарч, Асудын Өөдлөх нэртийг Батула чинсан бээр араг үүргэн аргал түүлгэж Аругтай хэмээн нэрийдэн зарж явжээ”²⁸. Үгэчи хашха урьдын өш санаж Хуухай тайюугийн хөвгүүн Батула чинсанг алсан ч, мөн удалгүй өөрөө нас барсан байна. Үгэчи хашха-гийн хөвгүүн Эсүхэ эцгээ залгамжлан Батула чинсангийн Самур гүнжийг авч, Өлзийт гоо хатанг хүү Ачай (Ажай) тайж, Аругтай гурвууланг нь гэртээ зарцалж байв.

Удалгүй Эсүхэ нас барсныг ашиглан, “Самур гүнж Үгэчи хашха-гийн муу хийснийг өслөн сэтгэж, Өлзийт хун гоо бэйж, Ажай тайж, Аругтай тайши гурвуулыг нууж гарган, төрхөмдөө Монгол улсад иргээсэн” ажээ.

Тэр цаг үед Хорчины Очигин эзний үр Адай тайж зүүн монголд хүчирхэг нөлөөтэй байсан бөгөөд

“Өлзийт гоо бэйжийг аван эзний өмнөөс хаан орноо сууж, Аругтайд тайши цол өгөөд, даруй Адай хаан, Ажай тайж, Аругтай тайши гурвуул эрхлэн морилж, Жаламан ханаа дөрвөн Ойрадыг довтолж олз болгон, Батулан чинсангийн хөвгүүн Багму-г барьж иржээ”.

²⁷ 明實錄 (Ming shilu). 宣宗實錄 (Xuanzong shilu). Сюаньдэ-ийн 9-р оны 4 сарын хар нохой өдөр; Сюаньдэ-ийн 9-р оны 8 сарын шар луу өдөр

²⁸ Саган Сэцэн. *Эрдэнийн товч*. Хөрвүүлэг тайлбар хийсэн М.Баярсайхан. УБ., 2015.т. 162.

Эрдэнийн товчид цаашид өгүүлэхдээ:

“Багму-г тогоонд хөмрөн, Тогоон хэмээн нэрийдэж, гэртээ заран явахуйд” ... “Самур гүнж биеэр ирж, Тогоон тайши хөвгүүнээ гуйн авч харьсан”²⁹ ажээ.

Монгол сурвалжийн мэдээгээр бол, Ойрадад олзлогдон Батула чинсан, Үгэчи хашха-гийн хөвгүүн Эсүхэ нарт зарцлагдан хүнд хэцүү амьдралыг туулсан Аругтай нь, Өлзийт гоо хатан, түүний хүү Ажай тайжийн хамт Самур гүнжийн туслалцаатай зүүн Монголд эргэн ирэхэд нь Хорчины Адай ноён хүлээн авчээ. Адай өлзийт гоо хатныг авч өөрийгөө хаан өргөмжлөхдөө Аругтайг *тайши* болгосон хэмээдэг. Адай хаан, Аругтай тайши нар Ойрадыг довтлон Жаламан хан ууланд ялалт байгуулж, Батула чинсангийн хөвгүүн Багму буюу Тогоон тайшийг олзолсон ажээ. Багму-г тогоонд хөмрөн зарцалж, Тогоон нэр өгсөн хэмээдэг.

Монгол сурвалж дахь араг үүрүүлж зарцалж явсан тул Аругтай гэх болсон, тогоонд хөмрөн зарцалж Тогоон нэр өгсөн гэдэг нь түүхэн үнэнийг өгүүлэхээсээ илүүтэй уран зохиолын өгүүлэмж шинжтэй, зүүн баруун Монголын гол нөлөө бүхий удирдагч, хоорондоо өрсөлдөн тэмцэлдэж явсан хоёр эрхмийг сөргөлдүүлэн тавьж, дүрийг нь товойлгосон өгүүлэмж хэмээн үзэх нь зүйтэй байх. Хэрэв Эрдэнийн товчийн дээрх мэдээнд үндэслэвэл, Адай хаан Аругтайг тайши болгосон болж таарах бөгөөд энэ нь хожуу үед холбогдож хятад сурвалжийн мэдээтэй илт зөрчилддөг билээ. Харин эсрэгээрээ, Аругтай тайши 1416 оны үед Хасарын угсааны Адай ноёнг хаан өргөмжилсөн³⁰ гэдэг нь түүхэн үнэнд илүү нийцэх нь тодорхой байна.

Аругтай тайшийг устгаснаар Монголын цэрэг, улс төрийн гол эрх мэдэл Ойрадын Тогоонд гарт төвлөрөх болжээ.

Тогоон тайши (1434-1439 он). 1417 оны 4 сард Ойрад руу илгээсэн Мин улсын элч иргэж буцаж ирээд “Өдгөө Махаму нас барж, сянь-и ван Тайван, аньлэ ван Батболд нар нэгэн сэтгэлээр улсад алба өргөж, үнэн сэтгэл гаргав” хэмээн мэдэгджээ. Мин улсын магад хуулийн мэдээг баримталбал 1417 онд Махаму нас барж, Ойрадын Тайван, Батболд нар Мин улсын хааны зарлигийг дагахаа илэрхийлсэн байна. Харин 1418 оны 3 сард Ойрадын Тайван, Батболд, түүний дүү Энх, Махамугийн хүү Тогоон (脫歡 tuohuan) нар Мин улсад адуугаар “алба барихад”, Тогоонд эцгийнх нь Шунь-нин ван цолыг залгамжлуулсан ажээ. 1417 оны 10 сард Ойрадууд Аругтайд ихээр ялагдсан тул Мин улсад дагаар орогчдын ихэнх нь Ойрадууд байгааг Мин улсын магад хуульд тэмдэглэсэн байдаг.

Тогоон, Тайван, Батболд нарын Ойрадын тэргүүлэх ноёд Мин улсад тус тусдаа байнга элч илгээн, найрсаг харилцаатай байв. Энэ нь Аругтайтай хийх тэмцэлдээ Мин улсыг түшиглэх бодлого явуулж байсантай холбоотой гэж үзэж болно.

1424 оны 10 сард Мин улсын хаан Ганьсугийн захирагчид буулгасан зарлигтаа:

²⁹ Саган Сэцэн. *Эрдэнийн товч*. Хөрвүүлэг тайлбар хийсэн М.Баярсайхан. УБ., 2015.т. 164-165.

³⁰ Энхцэцэг Д. *Монголчуудын түүх* (XIV зууны II хагасаас XVII зуун). УБ., 2023. т. 142.

“Ойрын үед сянь-и ван Тайван Ойрадын шүнньин ван Тогооны дайралтад өртөж, Тайваны хүн морь бутран сарниж, Ганьсүгийн хилд зугтан ирж, сэм суух этгээдүүд буй гэж сонслоо. Та нар даруй цэрэг морь гарган тандан шалгаад хэрэв үнэн бол хүн илгээн элсүүлэн дагуулж хамт ирэгтүн. ... Холоос дагаар ирэгсдийн итгэлийг бүү алд”³¹ хэмээжээ.

Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, Ойрадын Тайван нь Тогооны довтолгоонд өртөж, албат иргэд нь бутран сарниж, Ганьсүгийн хилийн ойролцоо ирж нутаглах болсон ажээ. Тогоон эцгийгээ залгамжилснаас хойш нэгэн үе Ойрадыг хуваан захирч байсан Тайван, Батболд нартай найрсаг харилцаатай байж, Аругтайн эсрэг хамтран тэмцэж байсан билээ. Харин энэ үеэс Ойрадад өөрийн ноёрхлыг тогтоох бодлого явуулах болж, Тайваныг довтолсон бололтой. Энэ нь Тогоон ихээхэн хүчирхэгжиж, Ойрадын гол хүчин болсныг харуулж байна.

1425 оны цагаан сард Ойрадын Батболдын хүү Иласа, аймгийн ахлагч Налиху, Энх, Тогоон нар тус бүр адуугаар Мин улсад “алба барьсан” гэсэн Мин улсын магад хуулийн мэдээнд Тайваны нэр байхгүй байгаа нь Тогоон, Батболд нар нь Тайваны эсрэг нэг эвсэл болсныг харуулж байж болох юм.

1426 оны хаврын тэргүүн сард Мин улсаас Ойрад руу элч илгээн Тайваны хүү Нэлэхү (捏烈忽)-д эцгийн нь сянь-и ван цолыг залгамжлуулж зарлиг хүргүүлжээ. Энэхүү зарлигт:

“Урьдын миний өвөг Тайзун хааны үеэс өнөөдрийг хүртэл чиний эцэг сянь-и ван Тайван хаант төрд хичээнгүйлэн үйлчилж, харилцан элч илгээн нэгэн гэр мэт байв. Би тэнгэрийн тохиолоор залгамжилсан эрдэнийн суудлыг хичээнгүйлэн хүндэтгэж, өвөг дээдсийн хууль цаазыг ёс болгох бөгөөд дэлхий дахины хүн ардыг хэн аль гэж ялгалгүй цөмийг сонсож тус болох нь миний цорын ганц хүсэл бүлгээ”³² гэжээ.

Мин улсын хаан Ойрадын ноёдыг хараат түшмэг хэмээн үзэж байсан нь дээрх зарлигаас тодорхой харагдана.

1430 оны 4 сард Ойрадын Тогоон “нум сум, хутга зэргийн юм гуйж” элч илгээсэнд Мин улсын хааны ордон бүгдийг нь өгсөн ажээ. Мин улсын сударт дагаар орсон хүмүүсийн мэдүүлснээр 1431 оны эхээр Аругтай, Тогоон нар байлдаж, Аругтай ялагдан, аймаг олон нь бутран сарнисан байна. Мөн түүнчлэн Аругтайн харьяаны зарим ноёд Мин улсад дагаар орж, “Аругтай Ойрадад шахагдаад гэр орон, харьяат хүмүүсээ дагуулан өмнөш явсан” хэмээн илтгэжээ. Мин улсын “түшмэлүүд цэрэг гарган гэнэдүүлэн цохих хүсэлт гаргахад” Аругтай тасралтгүй алба барьж байсан бөгөөд эдүгээ хөөрхийлөлтэй байдалд оржээ. “Би Дундад улсын хүчийг алс холын зэрлэгүүдийг шахахад зарцуулах хүсэлгүй бөлгөө” хэмээн Мин улсын хаан хэлснийг Мин улсын магад хуульд тэмдэглэжээ³³. Энэ нь Мин улс монголчуудтай харилцах довтлох тактикаасаа татгалзаж, хамгаалах тактикийн бодлогод шилжсэнийг тодорхой харуулдаг.

³¹ 明實錄 (Ming shilu). 仁宗實錄 (Renzong shilu). Юнло-ийн 22-р оны 10 сарын цагагчин гахай өдөр.

³² 明實錄 (Ming shilu). 宣宗實錄 (Xuanzong shilu). Сюаньдэ-ийн тэргүүн (1426) оны цагаан сарын улаан морь өдөр.

³³ 明實錄 (Ming shilu). 宣宗實錄 (Xuanzong shilu). Сюаньдэ-ийн 6-р оны 4 сарын шаргачин хонь өдөр.

1434 оны 7 сард Тогоон цэргээ удирдан Аругтайг довтлон алахад аймаг олон нь бутран сарнижээ. Энэ талаар Мин улсаас Тогоонд хүргэсэн зарлигт “Аругтайг хөнөөж хуучин өшөөгөө авсныг сонссон. Олж авсан хасбуу тамгыг өргөн барих хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн нь цөм вангийн санаа ажгуу”³⁴ хэмээн Тогооныг сайшаагаад тамгыг хүлээн авахаас Мин улс татгалзсан ажээ. Ойрадын Тогоон гол өрсөлдөгч болох Аругтайг устгаснаар түүний гарт цэрэг, улс төрийн эрх мэдэл төвлөрөх болсон. Тэрээр Тогтобуха-г Тайсун хэмээн хаанаар өргөмжилсөн. Хятад сурвалжид Шуньнин ван Тогоон хэмээдэг бөгөөд “тайши” гэж тэмдэглээгүй. Харин Монгол сурвалжид Тогоон тайши хэмээдэг. Аругтай тайшийг хөнөөж, Тогтобухаг хаанаар өргөмжилсөн Тогоон нь тайшийн суудлыг эзэлсэн нь тодорхой юм.

Мин улсын магад хуульд:

1436 оны 9 сард Мин улсын хаан хилийн хамгаалалтын жанждад хандан гаргасан зарлигтаа “Ойрад дайнд ялж, цэргийн хүч нь өдрөөс өдөрт нэмэгдэхийн дээр хүн илгээн Урианхай, Зүрчид аймгуудтай харилцаа тогтоож байгаа тэдний санааг таамаглах аргагүй”³⁵ хэмээн болгоомжилсноос үзэхэд Урианхайн гурван харуулд Тогоон нөлөөгөө бэхжүүлж, Урианхайчууд Тогооныг дагах болсон бололтой.

1438 оны 9 сард Ойрадаас буцаж ирсэн Мин улсын элч “хулгай Адай, Доржибай нар нэгэнт үгүй болж Тогтобуха ванд алагдаж, баруун хойд хил аюулгүй болсныг хэлсэн” ажээ. Энэ үеэс Тогтобуха хаан Мин улстай идэвхтэй харилцаж эхэлсэн байдаг. Адай хааныг устгаснаар Тогоон тайши, Тогтобуха хаан нар зүүн, баруун Монголыг нэгтгэн захирсан төдийгүй Урианхайн гурван харуулд нөлөөгөө тогтоон, үлэмж хүчирхэгжиж эхэлжээ. Гэвч Тогоон удаан насалсангүй. 1439 оны 11 сард “Тогтобуха болон Тогооны хүмүүс Харманлай хэмээх газар хуран цуглаад” байгаа талаар тэмдэглэснээр Тогооны нэр Мин улсын магад хуульд хамгийн сүүлд дурдагдсан байдаг. Мин улсын судар болон монгол сурвалжийн мэдээгээр Тогоон тайши 1439 онд нас барсан ажээ.

Эсэн тайши (1439-1454 он). Эсэн эцгийн тайши тушаалыг 1439 оны эцэс 1440 оны эхээр залгамжилж, үлэмж хүчирхэгжсэн ажээ.

Мин улсын судрын Ойрадын шастирт:

“Дөрөвдүгээр он (1439 он), Тогоон (脫懽 tuohuan) үхэж, хөвгүүн Эсэн (也先 yexian) залгамжлаад, тайши (太師 taishi), хуай ван (淮王 huaiwang) хэмээн нэрлэв. Тиймээс умардын аймгууд бүгд Эсэнд захирагдаж, Тогтобуха хоосон нэр төдий болоод түүнийг хяналтдаа байлгах боломжгүй болсон. Алба барих бүрдээ эзэн түшмэл хамтдаа элч зарж, засгийн газар бас хоёр зарлигийн бичиг буулган хариу барьж, өгөөмөр шан хишгийг тэдний эхнэр, аймгийн захирагч нарын хамт хүртээж байв”³⁶ хэмээснээс үзэхэд Эсэн тайши ихээхэн хүчирхэг байсан нь тодорхой юм.

³⁴ 明實錄 (Ming shilu). 宣宗實錄 (Xuanzong shilu). Сюаньдэ-ийн 9-р оны 10 сарын улаан морь өдөр.

³⁵ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жэнтунь тэргүүн (1436) оны 9 сарын шар бич өдөр.

³⁶ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8499 頁;.

Эсэн тайши бүс нутагтаа нөлөөгөө өргөтгөх бодлого явуулж, Хамиг довтлон вангийн ээж болон дүүг олзлон авсан. “Бас Шажоу (沙州 shazhou), Чигин Монгол (赤斤蒙古 chijin menggui)-ын олон харуултай ураг барилдаж, Урианхай (兀良哈 wuliangha)-г эвдэж, Часянь (朝鮮 chaoxian)-ийг сүрдүүлэх болсон”³⁷ тул Мин улсын хязгаарын жанжид ихэд болгоомжлон хааны ордонд өргөх бичиг илгээж байсан ч Мин улс олигтой арга хэмжээ авч чадаагүй талаар Мин улсын сударт тэмдэглэсэн байдаг. 1446 онд Урианхайн гурван харуул руу довтолсон. Ийнхүү Эсэн тайши Хами, Дуньхуаны бүс нутаг, Ганьсугийн Чигин Монгол харуул зэрэг баруун бүс нутаг, Ляодун дахь Урианхайн гурван харуулд нөлөөгөө тогтоон улам бүр хүчирхэгжин Мин улсыг сүрдүүлэх болов.

1449 оны намрын тэргүүн сард Монголын их цэрэг гурван замаар Мин улсад халдан довтолсон. Тогтобуха хаан Урианхай гурван харуулын цэргийн хамт Ляодуны чиглэлээр, Алаг чинсан Сюаньфү-ын чиглэлээр довтолж Ганьжоу халдав. Эсэн тайши Датун чиглэлийн цэргийг тус тус удирдан довтолсноор Монгол Мингийн дайн эхэлжээ. Энэ талаар Мин улсын сударт:

“Тогтобуха Урианхайг удирдаж Ляодун (遼東 liaodong)-ыг довтолж, Алаг жыюань (阿剌知院 Ala zhiyuan) Сюаньфү (宣府 zuanfu)-д довтолж, Чычэн (赤城 chicheng)-ийг бүсэлж, бас тусгай морьт цэрэг илгээн Ганьжоу (甘州 ganzhou)-г довтлов. Эсэн өөрөө Датун (大同 datong)-ыг довтлов”³⁸ хэмээжээ.

Мин улсын хаан өөрийн биеэр цэргээ удирдан Монголын цэргийг тосон байлдсан боловч амжилт олсонгүй, томоохон ялагдал хүлээн Мин улсын Инзун хаан олзлогджээ. Мин улсын сударт бичсэнээр

“Түмү нь өндөр газар, худгийг хоёр хос алд (二丈 er zhang)³⁹ ухсан ч ус гарахгүй, ус авах зам хэдүйн дайсанд эзлэгдсэн тул, хүмүүс цангаж, дайсны морьт цэрэг улам нэмэгдэв. Маргааш нь дайсан их цэрэг зогсож, цааш хөдлөхгүй байгааг хараад, хуурмагаар ухарсанд Жэнь (振 zhen) яаран тушаал буулгаж цэргийн хүрээг өмнө зүгт шилжүүлэхээр болов. Цэрэг яг хөдлөх үед Эсэн морьт цэргээ цуглуулж дөрвөн талаас довтолсонд, цэргүүд бие биеэсээ өрсөн дутааж, жагсаал ихэд үймэлдэв. Дайсан цэргийн байрыг даван орж ирсэнд, Зургаан цэрэг (六軍 liujun) ихэд ялагдаж, алагдаж шархдагсдын тоо хэдэн арван түм болов. ... Хуанди олзлогдов. Эсэн хуандийн хөсөг хүрч ирснийг сонсоод ... хуандийг дагуулан өөрийн дүү Баянтөрийн (伯顏帖木兒 boyantiemu'er) хүрээнд суулгасан”⁴⁰ ажээ.

Сурвалжийн мэдээнээс үзвэл, Түмүгийн байлдаанд Мингийн хэдэн арван мянган цэрэг, 50 гаруй ноёд, жанжид алагдаж, хаанаа олзлуулж, томоохон ялагдал хүлээсэн нь тодорхой байна. Энэхүү байлдааныг түүхэнд “Түмүгийн хэрэг”, “Түмүгийн хувирал” хэмээн нэрлэдэг. Эсэн нь хааныг нь олзолсноо ашиглан Мин улсад дарамт шахалт үзүүлж, “алтан зоос” өгөхийг шаардсан. Мин улс

³⁷ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8499 頁.

³⁸ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8500 頁.

³⁹ 丈 zhang. Хятадын уртын хэмжээ, 1 zhang нь ойролцоогоор 3,2 метр.

⁴⁰ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8500-8501 頁; Мин улсын судар, Ойрадын шастир. *Мин улсын судар*. III боть. Уб., 2018. т. 215-216.

олзлогдсон хааныхаа дүүг шинээр хаан өргөмжилж, Эсэнгийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнгүй. Тиймээс Мин улсын нийслэлийг довтолж, бүслэн байлдсан байна. Бээжинг довтолсон Эсэнгийн зорилго нь Мин улсаар буулт хийлгэж, найрамдлын гэрээ байгуулж, хилийн худалдаа нээх явдал байсан. Бээжингийн хамгаалалт сайн, эсэргүүцэл хүчтэй байсан болон “Тогтобуха, Алаг жыюань нар элч илгээн найрамдахыг хүсээд”, “өөрийн аймгаа эргүүлэн татаж буцан одсон тул Эсэн бас цэрэглэхээ зогсоохоор шийдсэн” ажээ. Ийнхүү Эсэн довтолгоогоо зогсоон, олзлогдсон Мин улсын хаан Инзуныг аван буцсан байна. Эсэн тайши Мин улс руу удаа дараа элч илгээн, найрамдал тогтоон, хуучин хааныг буцаах хүсэлт тавьж байсан ч Мингийн хааны ордон саналыг хүлээн авахгүй байв. Тиймээс Эсэн Мингийн умард хилийг байнга уулгалан довтолж, Мин улсад дарамт шахалт үзүүлж байжээ. Мин улсаас Эсэнг алсан хүнд мянган лан алт, 10 мянган лан мөнгө, мянган хуй торго шагнаж, ван өргөмжлөхөөр амлаж байв⁴¹.

Мин улс олзлогдсон хаанаа буцаан авахдаа ямар нэгэн болзол хүлээн авахгүй байх бодлогыг тууштай баримталсан нь харагддаг. Мингийн талаас өндөр түвшний элч Монголд очвол олзлогдсон хааныг буцаана гэсэн монголын талын саналыг Мин улс хүлээн авч, сайд Ян Шань нарын элчийг ирүүлсэн. Инзун хааны хөсөг 1450 оны найман сард буцахад нь монголын талаас хүндэтгэлтэйгээр үдэж, цэргээр хамгаалан Бээжинд хүргэжээ. Үүнээс хойш Мин улс монголын элч нарыг хүлээн авч, ордны худалдаа сэргэсэн. Алба барих нэрээр Монголоос ирэх элч нарын тоо үлэмж нэмэгдэж Мин улсад дарамт учруулах болсон тул элчийн тоог хязгаарлахыг Мин улс оролдож байв. Мин улсын хаанаас Эсэн тайшид бичсэн захидалд:

“Эдүгээ тайшийн томилж ирүүлсэн хүн олон, хоёр удаагийн нийт хүн 3000 илүү, хил хязгаарыг сахигч жанжин нар чөлөөтэй оруулахыг зөвшөөрөхгүй. Хаан би тайшийн үнэнч шударгыг санаж, зарлигаар цөмийг нь түр зуур тавив. Үүнээс хойш тайши гагц цөөн хүн ирүүлж болох, албан бичгийн нийт тоонд түшиглэн хил боомтын хориглолтоос хэтрүүлж удав”⁴² хэмээсэн байдаг.

Ирэх элчийн тоог цөөлөх шаардлагыг Мин улсаас удаа дараа тавьж байсан ч монголоос ирэх элчийн тоо цөөрсөнгүй, нэг удаа 2000 гаруй элч, дөрвөн түм илүү адуу тэмээ авч ирэх нь байв. Ийнхүү элчийг дагалдан ирэх худалдаачид болон малын тоог нэмэгдүүлсээр байжээ. Алба барих нэрийн дор Мин улсыг тагнан турших бодлого явуулж байна хэмээн Мингийн зүгээс ихээхэн болгоомжилж байсан ажээ. Эсэн тайши Мин улстай идэвхтэй харилцах, элчийн дагалдан хийх ордны худалдаанд үлэмж анхаарал тавьж байсан нь харагдана. Түүнчлэн Эсэнгийн үед баруун зүгт Хами, Чигин Монгол харуул болон зүүн тийш Урианхайн гурван харуулыг өөрийн нөлөөнд оруулж Монголчууд цэрэг, улс төрийн хувьд бүс нутагтаа үлэмж хүчирхэг болсон билээ. Гэвч Тогтобуха хаан, Эсэн тайши нар хоорондоо тэмцэлдэх болсон бөгөөд тэдний тэмцлийн шалтгааныг Мин улсын сударт:

⁴¹ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жэнтай-ын тэргүүн (1450) оны 2 сарын улаагчин тахиа өдөр.

⁴² 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жинтайгийн 4-р оны цагаан сарын улаан нохой өдөр

“Тогтобухагийн гэргий нь Эсэнгийн эгч юм. Эсэн эгчийнхээ хүүг хунтайж (太子 taizi) болгохыг хүсэхэд [Тогтобуха] татгалзсан. Эсэн түүнийг Дундад улстай харилцаж, өөрийн эсрэг хуйвалдаж магад хэмээн сэжиглэж, эцэстээ цэргээ засаж довтлов. Тогтобуха ялагдан дутаахад Эсэн нэхэн хөөж хороогоод, эхнэр хүүхдийг олзолж, түүний хүн малыг харьяат аймагтаа нэгтгэв. Эцэстээ ялсан эрчиндээ олон аймаг түшээг дарамтлан сүрдүүлсэн бөгөөд зүүн тийш Зяньжоу (建州 jianzhou), Урианхай (兀良哈 wuliangha), баруун зүгт Чигин (赤斤 chijin) Монгол, Хами (哈密 hami)-д хүрэв”⁴³ хэмээжээ.

Хятад сурвалжид хааны залгамжлагчаар өөрийн эгчээс төрсөн хүүг нь тодруулах гэсэн Эсэн тайшийн саналыг Тогтобуха хаан дэмжилгүй, өөр хатнаас төрсөн хүүгээ залгамжлагчаар сонгосонтой холбоотой зөрчил тэмцэл үүссэн хэмээн мэдээлдэг. Гэвч үнэн хэрэгтээ хаан, тайши хоёрын Монголын төрийн эрх мэдлийн төлөөх тэмцэл байсан нь ойлгомжтой юм. 1453 онд болсон хаан, тайши хоёрын хоорондын дайнд Эсэн тайши ялж, Тогтобуха хаан алагдсан байна. Жинтайгийн 4-р он буюу 1453 оны 10 сард Эсэн нь Мин улсад захидал илгээн, “адуу, булга, гүенгийн арьсаар алба барьжээ”. Эсэн захидалдаа өөрийгөө “Их Юань улсын Тяньшөн их хаан” хэмээсэн ажээ.

“Анх удаа Их Юань улсын Тяньшөн их хаан хэмээн нэрийджээ. Тяньшөн хэмээх үг нь тэнгэр богд гэсэнтэй адил болой, эцэст нь Юаний тэргүүн он хэмээн нэмэв”⁴⁴ хэмээн Мин улсын магад хуульд онцлон тэмдэглэсэн байдаг.

Дээрх сурвалжийн мэдээнээс үзвэл, Эсэн өөрийгөө Их Юань улсын тэнгэр богд их хаан хэмээн Монголын их хаанаар өргөмжилсөн ажээ. Гэвч алтан ургийн хүн биш тул Мин улс хүлээн зөвшөөрсөнгүй. Мин улсын магад хуульд “Ойрадын Эсэн дураар нэр цолоо өөрчилж”, “Эсэн өөрийн эзнээсээ тэсэлж, өөрийгөө хаан хэмээжээ” гэх зэргээр тэмдэглэсэн байдаг. Мин улсын хааны ордонд Эсэнийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар түшмэдийн зөвөлгөөн болж, “Ойрадын хаан” хэмээн нэрлэх нь зүйтэй гэж үзсэнээ хаанд айлтгахад, Мин улсын хаан “дахин хэлэлц хэмээн зарлиг болгожээ”. Түшмэлүүд дахин хэлэлцээд “хуучин хэвээр тайши хэмээн дуудахаар болж, богд эзнийг тасалж өгөхийг гуйв”. Мин улсын хаан “Ойрадын хаан” хэмээн дуудвал зохимуй⁴⁵ хэмээжээ. Үүнээс үзэхэд, Мин улсын зүгээс Эсэнийг Монгол улсын хаан гэж хүлээн зөвшөөрсөнгүй. Монгол улсын дотоодод ч алтан ургийн удмын хүн биш хэмээн Эсэн хааныг хүлээн зөвшөөрөхгүй, зөрчил тэмцэл өрнөж байжээ. Төрийн эрх мэдлийн төлөөх тэмцэл өрнөж, Эсэнгийн харьяат Алаг нь “тайши” цолыг өөртөө өгөхийг шаардахад, Эсэн өөрийн дэд хөвгүүнээ тайшиар өргөмжилсний улмаас зөрчил тэмцэл өрнөжээ. Мин улсын магад хуулийн 1454 оны 10 сарын хөх морь өдрийн Сюаньфү, Датун бүгдийн захирагч түшмэлийн айлтгалд, бууж өгөгчид болон олзноос зугтан ирэгчид бүгд хэлэх нь “хулгайн түрүү Эсэнг жыюань Алаг алж

⁴³ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8502 頁; Мин улсын судар, Ойрадын шастир. *Мин улсын судар*. III боть. Уб., 2018. т. 220-221.

⁴⁴ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жинтайгийн 4-р оны 10 сарын шар нохой өдөр

⁴⁵ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жинтайгийн 4-р оны 12 сарын цагаачин үхэр өдөр

хороосон”. “Жыноань Алаг тайши болохыг гуйсан ч Эсэн зөвшөөрсөнгүй, даруй өс хонзон үүсэв” хэмээн тэмдэглэжээ⁴⁶. Мин улсын сударт:

“Удалгүй тэрээр (Эсэн) өөрийн харьяат Алаг жыноань (阿剌知院 ala zhiyuan)-д алагдав. Татар аймгийн ахлагч Болай (孛來 beilai) дахин Алагийг довтлон бутцохиж, Тогтобухын хөвгүүн Маркер (麻兒可兒 ma'erke'er)-ийг хаан өргөмжлөөд, бага хаан (小王子 xiaowangzi) хэмээв⁴⁷ гэжээ.

Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, Эсэн тайши өөрийгөө хаанаар өргөмжилсөн боловч хаан ширээнд удаан сууж чадсангүй, өөрийн албат Ойрадын Алаг жыноаньд алагдсан. Энэ үйл явдлыг Мин улсын магад хуульд 1454 оны 10 сард хэд хэдэн удаа тэмдэглэсэн бол, Мин улсын хуульд 1455 онд болсон тэмдэглэсэн байдаг. Мин улсын судрын Ойрадын шастирт 1453-1454 оны Эсэнгийн үйл ажиллагааны талаар тэмдэглэлгүй, шууд 1455 онд алагдсан хэмээн тэмдэглэсэн байна. Үүнээс үзэхэд Мин улсын магад хуулийн он цаг илүү үнэмшилтэй, үйл явдлыг нарийн тэмдэглэсэнд үндэслэн Эсэн 1454 оны намар нас барсан хэмээн үзэх нь зүйтэй юм. Зүүн монголын нөлөө бүхий ноён Болай нь Алаг чинсанг довтлон бутцохиод, Тогтобухын хөвгүүн Маркерыг хаан өргөмжилсөн ажээ. Энэ үеэс хятад сурвалжид Монголын их хааныг “бага хаан” буюу “сяованзы” хэмээн нэрлэх болсон.

Болай тайши (1455-1466). Эсэн тайши алагдсаны дараа зүүн Монголын нөлөө бүхий ноён Болай Ойрадын Алагийг довтлон цохиод, тайшийн суудлыг эзлэн хүчирхэгжсэн байна. Мин улсын магад хуульд тэмдэглэснээр Жинтайгийн 6-р оны (1455 он) 4 сарын шар нохой өдөр “Умардын хаан Маркер” болон “пинжан Энх, Муу нохой, Болай нар” Пирмахэма нарын элч илгээн “адуу тэмээгээр бариулж нийслэлд ирүүлсэн” ажээ. 1455 оны 5 сард элч Пирмахэма нар элчээр ирээд буцахад нь Мингийн хаанаас өнгөт торго бэлэглэж, буцаж очоод хаан Махагүргис болон пинжан Энх нарыг шагнах талаар зарлиг уламжилсныг тэмдэглэжээ⁴⁸. Түүнчлэн Тайнин харуулын захирагч Гэгээнтөмөрийн элч Мин улсад 1455 оны 8 сард ирээд өгүүлсэн:

“Хулгайн түрүү Муулихай даруй Тогтобуха вангийн отгон хөвүүнийг ван (хаан) болгож, Муулихай (卯裡孩 maolihai) тайши (太師 taishi) болж дэвшив. Ойрын үед Муулихай цэрэг морьдоо дагуулан манай гурван харуулыг уулгалж, манай гурван харуул нийлж нэхэмжлэн нэгэнт тэдний олныг ялав⁴⁹ гэжээ.

Сурвалжийн дээрх мэдээ нь 1455 оны хавар гэхэд Муулихай нь Тогтобухын хөвгүүнийг хаан өргөмжилж, өөрөө тайши болсон хэмээдэг. Харин Мин улсын сударт:

⁴⁶ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жинтайгийн 5-р оны 10 сарын хөх морь өдөр

⁴⁷ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8471

⁴⁸ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жинтайгийн 6-р оны 4 сарын шар нохой өдөр; 5 сарын хар нохой өдөр.

⁴⁹ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жинтайгийн 6-р оны 8 сарын шарагчин тахиа өдөр.

“Алаг үхэж, Болай (孛來 beilai) болон түүний харьяат Муулихай (毛里孩 maolihai) нар бүгд аймгийн дотор хүчирхэг хүндтэй хэмээн зөвшөөрөгдсөн тул Татар дахин хүчирхэгжив”

хэмээснээс үзэхэд Болай тайши, Муулихай ван нар Монгол улсыг нэгтгэхийн төлөө нэгэн үе хүч хавсран зүтгэж явжээ. Эндээс үзвэл Тайнин харуулын захирагчийн мэдээлэлд Болайг тайши болсныг Муулихай ванг тайши болсон хэмээн андуурсан бололтой. Мин улсын хаанаар Инзун 1457 онд дахин өргөмжлөгдөөд Баянтөрийн гэргийд торго шагнаж элч илгээсэнд Болай элчийг замаас нь барьж хорьсон. Тэрээр Мин улс хаанд элч илгээн баяр хүргэсэнд Инзун хаан “манай элчийг саатуулж, өөртөө гай зовлон бүү дуудагдун” хэмээсэн гэж Мин улсын судрын Татарын шастирт тэмдэглэсэн байдаг. Болай тайши 1458 онд Шэньсид, дараа жилийн хавар Аньбянь хүрээнд, 1460 онд Юйлинь болон Шэньсид, 1461 онд Пинлү хотод халдан довтлох⁵⁰ зэргээр Мин улсын хил хязгаарт байнга халдах болсноос үзэхэд Болай тайшийн нэр хүнд өсөн хүчирхэгжсэн нь тодорхой байна. Мин улсын сударт “Намар нь Болай дагаар орохыг гуйж”, “элч илгээн ... алба (貢 gong) барихаар ирж, Датун (大同 datong)-ы хуучин алба барих зам (貢道 gongdao)-ыг засаж, Шэньсийн Лань сяниар (陝西蘭縣 shanxi lanxian) ордог болохыг гуйсанд зөвшөөрөв” хэмээн тэмдэглэсэн атлаа “Удалгүй дахин өөрийн харьяат Муулихай нарыг цуглуулж Хэси (河西 hexi)-д довтлов” хэмээжээ. Дараа жил нь “Болайн элчид зарлиг буулгаж урьдын адил Датунаар алба бариулахаар болов”⁵¹ гэснээс үзэхэд 1462 оны намраас Болай тайшийн элчийг Мин улс хүлээн авч худалдаа хийх болж, худалдааны шинэ зам нээсэн ч дараа жилээс нь уламжлалт Датунгаар элч хүлээн авч худалдаа хийхээр болсон байна.

Мин улсын судрын Татарын шастирт:

“Болай жил бүр алба барьж, олон удаа уулгалан дээрэмдэх бөгөөд боомтын гадна ирж очин, баруун зүгт Ойрад (瓦剌 wala)-ыг довтолно хэмээгээд, бас олон удаа гурван харуул (三衛 sanwei)-ыг довтлон булаан дээрэмдсэн билээ. 7-р оны (1463 он) өвөл алба барих элч боомтод хүрмэгц, хуанди татгалзав”⁵² хэмээжээ.

Эндээс үзвэл, Болай тайши Монгол улсыг төлөөлөн Мин улстай харилцаж, хил хязгаарт нь халдан довтолж, шаардлага тавьж байсан ажээ. Мин улс ч Болайн шаардлагаар хилийн худалдаа болон худалдааны зам нээсэн ч удалгүй хаах зэргээр шахалт дарамт үзүүлж байв. Тиймээс 1463 оны өвөл Болай тайшийн илгээсэн элчийг Мин улс хүлээн аваагүй нь худалдааны хориг тавьж, монголчуудаар буулт хийлгэх гэсэн Мингийн хааны ордны бодлоготой холбоотой юм.

Чэнхуа (成化 chenghua)-ын тэргүүн он буюу 1465 оны хавар “Болай Урианхайн (兀良哈 wuliangha) есөн түмэн морьт цэргийг дагуулж Ляохэ (遼

⁵⁰ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8471 頁

⁵¹ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8472 頁

⁵² 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8472 頁; Мин улсын судар. III боть. УБ., 2018. т. 150.

河 liaohe)-д нэвтэрч” довтолсон бол, намар нь Яньань, Сүйдэ-д халдаж, өвөл нь дахин довтлох зэргээр Мин улсын хил хязгаарыг сүйтгэж байв. Улмаар Хуанфүчуань бэхлэлтийг бүслэн байлдсан ч цэргээ эргүүлэн татсан хэмээн Мин улсын сударт тэмдэглэсэн байдаг⁵³. Хятад сурвалжийн мэдээнээс үзвэл, Болай тайши Урианхайн гурван харуулын цэргийг дагуулан Мин улсын зүүн хойд хилийг түйвээж байсан төдийгүй Мингийн хойд болон баруун хойд хил хязгаарт байнга халдан довтолж, цэргийн сүр хүчээр далайлгаж байсан байна. Монголчууд Мингийн умард хил хязгаарыг довтолох нь ширүүсэж, түйвээх нь ихэссэн талаар Мин улсын судрын Татарын шастирт:

“Жинтай (景泰 jingtai, 1450-1456)-ын эхэн үед Яньчин (延慶 yanqing)-д халдсан боловч, аймаг нь цөөн учир гүн нэвтэрч зүрхэлсэнгүй. Тяньшүний үед (天順 tianshun, 1457-1464 он), Оручи (阿羅出 aluochu) гэгч албатаа дагуулж Бортохой (河套 hetao)-д нууцаар нэвтрэн нутаглан суусаар эцэстээ баруун хил хязгаар (西邊 xibian)-г ойртон түрэн орж ирэв. ... Мин улсын эхэн үед тус газрыг сахин хамгаалсан боловч, хожим нь эзгүйрэн атаршиж дотогш шилжүүлэв. Энэ үед хүрч ирээд, Болай хийгээд бага хаан, Муулихай тэргүүтэн урьд хожид ээлжлэн хүрч ирсээр байв. Олзлогдсон Дундад улсын хүнийг газарч болгон Яньсүй (延綏 yansui) газрыг хоосортол дээрэмдсэний улмаас хил хязгаарын хэрэг түгшүүртэй болов”⁵⁴ хэмээжээ.

Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, 1450-иад оны дунд үе хүртэл буюу Тогтобуха хаан, Эсэн тайшийн үед Мин улсын умард хил хязгаарыг довтолж байсан ч Бортохой, Ордосын нутагт монголчууд төдийлөн гүнзгий нэвтэрч чадаагүй ажээ. Харин Болай тайшийн үед Шар мөрний Бортохойд нэвтрэн орж, хяналтаа тогтоон байнга нутаглах болсон ажээ. Яньсүйг байнга довтолж, тонон дээрэмдэх болсон нь Ордос дахь ноёрхол хяналтаа бэхжүүлэх, Мин улсаар хүлээн зөвшөөрүүлэх бодлоготой нь холбоотой бололтой. Болай тайши, Муулихай вангаас гадна Оручи хэмээх ноён энэ үеэс Ордост нутаглах болжээ. Мин улсаас Ордосын нутаг дахь хяналтаа сэргээх зорилгоо удаа дараа довтолгоо хийж байсан ч амжилт олсонгүй. Монголчуудын довтолгоо нь Ордостой хил залгаа хязгаар нутгаа хамгаалалтаа сайжруулахад анхаарахаас аргагүй байдал хүргэсэн байдаг.

1466 оны зун Монголын цэрэг Яньсүй руу томоохон довтолгоо хийгээд улмаар Пинлянг тонон дээрэмдэж, Линжоу болон Гүюаньд халдсан төдийгүй өвөл нь дахин Яньсүйд халдан довтолжээ⁵⁵. Мингийн умард хил хязгаарыг байнга довтолж, Ордост ноёрхлоо тогтоон хүчирхэгжиж байсан Болай тайши нь Махагүргис хаантай эвдрэлцэн тэмцэлдэж, энэ тэмцэлд нь хаан ширээ, эрх мэдлийн төлөө дотоодын тэмцэл болон өргөжин тэлэв. Энэ тэмцэл нь Болай тайши Муулихай ванд алагдсанаар төгсжээ.

Муулихай ван (1466-1472). Болай тайши алагдсанаар засаглалын эрх мэдэл Муулихай ванд төвлөрч, Монголын хамгийн нөлөө бүхий ноён болов. Энэ талаар Мин улсын сударт:

⁵³ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8472 頁

⁵⁴ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8472-8473 頁

⁵⁵ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8473 頁.

“Удалгүй олон аймаг хоорондоо тэмцэлдэж, Болай (孛來 beilai) нь Махагүргис (馬可古兒吉思 makegu'erjisi)-ийг хороож, Муулихай (毛里孩 maolihai) нь Болайг хороогоод, дахин хаан өргөмжлөв. Оручи (斡羅出 wuluochu) гэгч дахин Муулихайтай дайсагналцаж алахыг завдсанд, Муулихай өргөмжилсөн хаанаа хороож, Оручиг хөөн зайлуулаад, элч илгээж (遣使 qianshi) алба барив (入貢 rugong). Улмаар мөрнийг гаталж, Датун (大同 datong)-ыг дээрэмдэв”⁵⁶ хэмээжээ.

Мин улсын судрын Татарын шастирын мэдээг баримталбал, энэ хэрэг явдал Болай тайши нар Яньсүйд халдан довтолсон 1466 оны өвлөөс хойш “удалгүй” болжээ. Тиймээс 1466 оны сүүлээр Болай тайши Муулихай ванд алагдсан хэмээн үзэж болно. Мин улсын магад хуулийн мэдээ үүнийг бас баталдаг.

Улмаар Муулихай ван Оручи шигүстэй хийсэн тэмцэлдэлд ялж, Оручи зугтаасан ажээ⁵⁷.

Чэнхуагийн 3-р он буюу 1467 оны цагаан сарын улаан хулгана өдрийн тэмдэглэлд:

“Саяхан Болай тайш Маркус Махагүргис (馬兒苦兒吉思 ma'er ku'er jisi) хаан (可汗 kehan)-ыг хөнөөхөд, Мулихай дахин Болайг алж, дараа нь шинэ хаан өргөмжлөв. Оручи шигүс (斡羅出少师 wuluochu shaoshi) хэмээх хүн Муулихайтай дайсагнав. Мулихай дахин шинэ хаанаа хөнөөж Орочу шигүшийг хөөсөн. Одоо улсын дотор тайван болсон болохоор найрамдалтай харьцахыг хүснэ”⁵⁸ хэмээнснээс үзэхэд,

Болай тайши Махагүргис хааныг алж, Муулихай бас Болайг алж, шинэ хаан өргөмжилсөн тухай Муулихайн элч Мин улсад ирж мэдэгдсэнийг тэмдэглэжээ. Түүнчлэн Оручи шигүс нь Муулихай ванг эсэргүүцэн тэмцэлдээд ялагдан зугтсан ажээ.

Ийнхүү Муулихай ван Болай тайшийг хороосноор Монголын хамгийн нөлөө бүхий эрх мэдэлтэн болжээ. Энэ үеэс Муулихайн нэр хятад сурвалжид байнга тэмдэглэгдэх болсноос үзэхэд тэрээр Болайн тайшийн тушаалыг авч, тайши болсон хэмээн үзэж болно. 3-р он буюу 1467 оны хавар Мингийн хаан Муулихайн эсрэг цэрэг илгээсэн бөгөөд “Тэр үед Муулихай дахин алба барьж харилцахыг гуйсан төдийгүй өөр аймгийн Боунай бас хүн илгээж, бараалхахаар ирсэн” байна. 1468 оны намар хааны ордонд өргөсөн Мингийн түшмэлийн айлгалд “Муулихай удтал алба барьсангүй, хил хязгаарт санаархах тул түүний нөхцөл байдлыг таамаглахуйяа бэрх” хэмээгээд тэднийг ялах аргыг санал болгосон байдаг. Муулихай нар хил хязгаарын газар хүртэл 2-3 өдрийн зайтай газарт хүрээлэн буусан байгаа бөгөөд тэд холоос ирсэн тул агт морьд нь ядарсан байгаа. “Сүүлийн үед өвс усыг дагаж тархан сарнисны улмаас аймаг нь дөрөв хуваагдаж, цэргийн хүч нь нэгдээгүй” байгаа тул шилмэл хоёр түмэн цэргийн хүчээр Муулихай ванг гэнэдүүлэн довтолхыг санал болгосон байдаг. Гэвч хуанди түүнийг сайшаасан боловч хэрэглэж чадсангүй хэмээн Мин улсын сударт тэмдэглэжээ⁵⁹.

⁵⁶ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8473 頁.

⁵⁷ 明實錄 (Ming shilu). 憲宗實錄 (Xianzong shilu). Чэнхуагийн 3-р оны цагаан сарын улаан хулгана өдөр.

⁵⁸ 明實錄 (Ming shilu). 憲宗實錄 (Xianzong shilu), Чэнхуагийн 3-р оны цагаан сарын улаан хулган өдөр.

⁵⁹ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8473 頁.

Эндээс үзвэл, Муулихай ван албат харьяатаа дагуулан Мингийн хилээс 2-3 өдрийн газарт удаан хугацаагаар сууж, албат иргэд нь улс бэлчээр даган хуваагдан, тархан суудаг байсан ажээ. Ийнхүү Муулихайг Мин улсын хилийн ойрхон сууж байгаа хэмээсэн нь Ордост нутаглаж байсныг өгүүлж байгаа хэрэг хэмээн үзэж байна.

Тэрээр 1468 оны өвөл Мин улсын хил хязгаарыг довтолсон бөгөөд 1469 оны хавар дахин халдахад нь Мингийн цэрэг няцаасан ажээ. Өвөл нь Урианхайн гурван харуулын цэргийн хамт довтолж, Яньсүй, Юйлин зэрэг газрыг ихэд сүйтгэсэн гэсэн хятад сурвалжийн мэдээнээс үзэхэд Мин улсын цэрэг Монголчуудын довтолгоог зогсоож чадахгүй байсан ажээ. Мин улсын сударт 6-р он буюу 1470 оны хаврын үйл явдлыг тэмдэглэхдээ:

“Тэр цагт Болунай (孛魯乃 beilunai) болон Оручи (斡羅出 woluochu) өөр аймгийн Бэгэрсэн (乧加思蘭 qiejiasilan), Болоху (孛羅忽 beiluohu) нартай нийлж Бортохой (河套 hetao)-г эзлэн суурьшсан бөгөөд удаан хугацаанд нутаглах санаатай”⁶⁰ хэмээжээ.

Хятад сурвалжид Болох жонон Баянмөнхийг цолоор нь Болоху хэмээн бичсэн байдаг бөгөөд Мин улсын сударт ийнхүү Бэгэрсэний хамт анх тэмдэглэгджээ. 1470-аад онд Монголын нөлөө бүхий ноёд болох Болунай, Оручи, Бэгэрсэн, Болох жонон Баянмөнх нар Ордосын Бор тохойд байнга нутаглах болсноос үзэхэд Ордос нутагт монголчууд хяналтаа бүрэн тогтоосон байсныг харуулна. Хятад сурвалжид Оручи (斡羅出 woluochu) нэрээр тэмдэглэгдсэн зүүн монголын хүчирхэг ноён бол монгол сурвалжид Оручи шигүс нэрээр гардаг. Түүний удам гарал, аль аймгийн удирдагч болох талаар судлаачдын санал ихэд зөрөөтэй байдаг.

Мин улсын хааны ордноос хил хязгаарыг хамгаалах жанжид, түшмэдийг шинээр томилж, цэрэг нэмж илгээжээ. Мин улсын хилийн хамгаалалтын жанжид олон удаа тулалдаанд ялсан хэмээн мэдүүлж, шан хишиг хүртэж, үе улиран залгамжлах ноёны цол хүртэж байсан ч монголчууд урьдын адил Бортохой (河套 hetao)-г эзлэн суусаар байсан⁶¹ хэмээн Мин улсын сударт тэмдэглэсэн байдаг. Энэ үед Мин улс цэрэг монголчуудын довтолгоог зогсоохын тулд олон удаа довтолгоо хийсэн ч төдийлөн амжилт олоогүй тул хамгаалах тактикт баримтлах болсон байв. Тиймээс монголчуудын довтолгоог тосон байлдаж няцаах тактикт түлхүү анхаарч, довтолгоог амжилттай няцааж, монголчууд цэргээ татсан тохиолдолд мөрдөн хөөж дарахыг оролдож байжээ.

Энэ үед зүүн монголын ноён Бэгэрсэн үлэмж хүчирхэгжиж Муулихай тайшийн гол өрсөлдөгч болж эхэлснийг хятад сурвалжийн мэдээ нотолж байна. Чэнхуагийн 5 дугаар он буюу 1469 оны 5 сард Ганьсугийн захирагч:

“Бэгэрсэн дөрвөн түмэн морьт цэргээ дагуулан, Баси Коутун очиж суув. Тэднийг Баясах болон Нувандаширын хүмүүс цөм нэгэнт биширч хоёр тэргүүлэгч ... олон жоу-д түрэмгийлэхийг хүсмүй” хэмээн айлтгахад,

⁶⁰ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8474 頁.

⁶¹ 明史 (Mingshi), 卷 327 鞑靼, 8474 頁.

Цэргийн яамнаас өгүүлсэн нь:

“Бэгэрсэн сүлжилдэх олон харийн дунд, баруун хойд талын хүчирхэг дайсан нь үнэн болно. Эдүгээ ... зах хязгаарын хилд суурьшихад Хами, Ойрад хоёр аймаг” түүнийг дэмжиж байгаа тул сэрэмжлэх хэрэгтэйг анхааруулсан байдаг⁶².

Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, 1469 он гэхэд Бэгэрсэн үлэмж хүчирхэгжиж, монголын улс төрд нөлөө бүхий ноёны нэг болсон нь тодорхой харагдана. Мин улсын судрын Сяньзун хааны цадигт Чэнхуагийн 7-р он (1471 он)-д “Энэ жил Бэгэрсэн (乜加思蘭 qiejiasilan) Бортохой (河套 hetao)-г эзлэн сууж, Орачу (斡羅出 woluochu)-тай нэгдэв”⁶³ хэмээснээс үзэхэд 1471 он гэхэд Бэгэрсэн Ордосын Бортохойд суурьших болжээ.

1471 оны өвлийн Монгол цэргийн довтолгоонд Мингийн хил хамгаалалтын цэрэг удаа дараа ялагдсан тул цэрэг илгээж “Бортохой-г аварч туслахыг хүссэн” байдаг. Улмаар Муулихай ван нарын сүр хүч аажмаар доройтож, Мандуул хаанаар өргөмжлөгдөн, түүний Бэгэрсэн тайши хүчирхэгжиж эхэлсэн ажээ.

Бэгэрсэн (Бег Арслан) **тайши** (1472-1478 он). Мандуул хаан өргөмжлөгдөн Бэгэрсэнд түшиглэн Монголыг нэгтгэхийг бодлого явуулжээ. Тиймээс Мандуул хаан, Бэгэрсэн тайши нар хүчирхэгжиж, Муулихай ван, Болунай, Оручи нарын сүр хүч буурсан байна. 7-р он буюу 1471 оны өвөл монголчууд Мин улсын хилд халдаж, мингийн цэрэг удаа дараа дараа ялагдахад хааны ордон олигтой арга хэмжээ авч чадаагүй ажээ. Умард хилийн хамгаалалтын цэргийн жанжидыг шинээр томилсон ч амжилт олсонгүй. Улмаар монголын цэрэг Яньсүйд ихэд халдахад мингийн цэрэг мөн л хамгаалж чадаагүй тухай Мин улсын сударт өгүүлээд, үргэлжлүүлэн тэмдэглэсэн нь:

“Харин Муулихай (毛里孩 maolihai), Болунай (孛魯乃 beilunai), Оручи (斡羅出 woluochu) нар улмаар доройтож, Мандуул (滿都魯 mandulu) Бортохой (河套 хэтао)-д нэвтрэн орж, хаан (可汗 kehan) хэмээн өргөмжилж, Бэгэрсэн (乜加思蘭 qiejiasilan)-ийг тайши (太師 taishi) болгов”⁶⁴ гэжээ.

Мин улсын судрын мэдээг баримталбал, Мандуул Ордост орж нутаглан, хаан өргөмжлөгдөж, Бэгэрсэн түүний тайши болсон нь 1472 оны хэрэг явдал хэмээн үзэж болохоор байна. Учир нь энэ үйл явдлын дараагаар 9-р он буюу 1473 оны хэрэг явдлыг Мин улсын судрын Татарын шастирт өгүүлсэн нь Мандуул 1473 оноос өмнө хаан өргөмжлөгдсөнийг баталж байна. Судлаачид Хураангуй алтан товчийн “хонь жил хаан ширээнд суугаад гахай жил нас барсан”, Шар туужийн “38 насандаа хаан ширээнд сууж, 42 насандаа нас барсан” хэмээн мэдээ болон Мин улсын Сяньзун хааны магад хуулийн Чэнхуагийн 11-р оны 10 сарын шарагчин туулай өдрийн мэдээг үндэслэн Мандуулыг 1475 онд хаан өргөмжлөгдөж, 1479 онд нас барсан⁶⁵ хэмээн үзэх нь буй.

⁶² 明實錄 (Ming shilu). 憲宗實錄 (Xianzong shilu). Чэнхуагийн 5-р оны 5 сарын цагагчин үхэр өдөр

⁶³ 明史 (Mingshi), 卷 13 憲宗, 168 頁

⁶⁴ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8474 頁.

⁶⁵ Буяндэлгэр. XV зууны эхэн хагасын Умард Юань улсын хаадын угсаа залгамжлал ба төрийн байдал. *Acta Historica*. Tom. XIX, Fas. 6, УБ., 2018. Хятад хэлнээс орчуулсан Б.Мягмаржав. т. 92-93

Чэнхуагийн наймдугаар оны (1472) цагаан сард:

“Дайсны удирдагч Бэгэрсэн нь Орочугийн аймагтай нийлэн гол гатлан хил хязгаарт халдсан. Жилийн дараа, тэд хоорондоо алалцаж, хоёр бүлэгт хуваагдав”⁶⁶ хэмээсэн Мингийн сурвалжийн мэдээнээс үзвэл, Бэгэрсэн, Орочу шигүш нар 1473 он үеэс хоорондоо дайсагнах болжээ.

9-р он буюу 1473 оны намар “Мандуул тэргүүлэн Болоху (孛羅忽 beiluohu) хамтдаа Вэйжоу (韋州 weizhou)-г довтолсон” ажээ. Мин улс цэрэг илгээн Мандуул хааныг тосон байлдахад “Мандуул ялагдаж эргэн одсон бөгөөд адуу мал, гэр бараа нь бүгд үгүй болж, эхнэр хүүхэд нь цөм үхэж үрэгджээ”. Үүнээс хойш хэсэг хугацаанд тэрээр Бор тохойд нутаглаагүй бөгөөд “хил хязгаарын зовлон бага сагаар үгүй болсон”, “хил хязгаарт заримдаа халдах боловч томоохон довтолгоо хийхээ больж, бас хэдэн удаа элч илгээн алба барив”⁶⁷ хэмээн Мин улсын сударт тэмдэглэсэн байдаг. Сурвалжийн дээрх мэдээнд хятад сударчдын хэтрүүлэг байж болох ч Мандуул хаан ялагдаж, хэсэг хугацаанд Бор тохойд нутаглаагүй юм байна.

Мин улсын сударт:

“Анхандаа Бэгэрсэн нь охиноо Мандуулд гэргий болгон өгөөд түүнийг хаан (可汗 kehan) болгов. Нэлээд хугацааны дараа Болоху-г хороож, түүний олныг өөртөө нэгтгээд, улам дур зоргоор авирлах болсон. Мандуулын харьяат Толохань (脫羅干 tuoluogan), Исмаил (亦思馬因 yisima'yin) нар хуйвалдан [Бэгэрсэнийг] хороов. Удалгүй Мандуул бас үхэж, олон хүчирхэг тэргүүлэгч дараалан үгүй болсноор хязгаарын иргэд амсхийх чөлөө олов”⁶⁸ хэмээжээ.

Ийнхүү Мандуул хаан, Бэгэрсэн тайши нар Болоху жонон Баянмөнхийг хороосноор улам бүр хүчирхэгжиж болов. Гэвч Мандуул хаан, Бэгэрсэн тайшийн нөхөрлөл удаан үргэлжилсэнгүй, хоорондоо зөрчилдөж эхэлсэн. Мин улсын судрын мэдээнээс үзвэл, Бэгэрсэн тайши нь “Болоху-г хороож, түүний олныг өөртөө нэгтгээд, улам дур зоргоор авирлах болсон”. Бэгэрсэн улам бүр хүчирхэгжин дураараа авирлах болсонд Мандуул хаан дургүйцэн, Толохань, Исмаил нартай нийлэн Бэгэрсэн тайшийг хороосон ажээ. Монголын их хаан тайши хоёрын хооронд болсон тэмцэлд ялсан нь Мандуул хааны байр суурийг ихэд бэхжүүлсэн нь тодорхой юм. Иймд Мандуул хааны Бэгэрсэн тайшийг устгасан үйл явдал нь алтан ураг хүчирхэгжихэд чухал нөлөө үзүүлсэн хэмээн үзэх нь зүйтэй юм. Гэвч удалгүй Мандуул хаан нас барсан билээ.

Мин улсын сударт эдгээр үйл явдал болон Бэгэрсэн тайшийн алагдсан оныг тодорхой тэмдэглэсэнгүй. Зарим судлаач Бэгэрсэнийг 1475 онд алагдсан хэмээн үзсэн нь үнэмшилгүй. 1477 онд “Мандуул (滿都魯 mandulu), Бэгэрсэн (乧加思蘭 qiejiasilan) нар тус тус элч илгээн, мориор алба өргөсөн”⁶⁹ тухай Мин улсын судрын Сяньзун хааны намтрын бүлэгт тэмдэглэсэн байдаг. Мандуул, Бэгэрсэн нар 1477 оны хэдэн сард элч илгээн Мин улстай харилцсаныг тодорхой тэмдэглээгүй

⁶⁶ 徐日久 (Siurijiu). 五边典则 (wubiandianze). 明代蒙古汉籍史料汇编. 第五辑. 2006. 400 頁.

⁶⁷ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8474 頁.

⁶⁸ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8474-8475 頁.

⁶⁹ 明史 (Mingshi), 卷 14, 憲宗二, 174 頁.

боловч Бэгэрсэн 1477 оноос хойш нас барсан нь тодорхой юм. Хятад сурвалжид 1478-1479 онд мингийн умард хилд монголчууд халдан довтолсон талаар тэмдэглэл харагдахгүй байгаа нь Мандуул хаан Бэгэрсэн тайши нар хоорондоо тэмцэлдэж, мингийн хил хязгаарт довтолохоо больсныг харуулж байж болох юм. Тиймээс хятад сурвалжид “хязгаарын иргэд өчүүхэн амсхийх чөлөө олов” гэж тэмдэглэсэн байх.

“Мингийн үеийн умард бүдүүлгийн шинжилгээ” (皇明北虏考 Huangming Beilukao) зохиолд Чэнхуагийн 15-р он (1479)-д “Мандуул Бэгэрсэнийг алсан” хэмээжээ⁷⁰. Харин Мин улсын магад хуульд 1479 оны 5 сард умардын удирдагч Бэгэрсэн нь Исмаилд алагдсан хэмээгээд, үргэлжлүүлэн Бэгэрсэн нь Мандуулыг хаан өргөмжлөөд, охиноо түүнд өгч ураг барилдан, өөрөө тайши болсон. Гэвч Толохань, Исмаил нар хуйвалдан Бэгэрсэнийг алж, Исмаил тайши болсон хэмээн⁷¹ он цагийг тодорхой тэмдэглэсэн. Иймээс Мин улсын магад хуулийн мэдээг баримтлан Бэгэрсэн тайши 1479 онд алагдаж, Исмаил тайши болсон хэмээн үзэж байна. Чэнхуагийн үед Мин улс нь Монголын эсрэг худалдааны хориг арга хэмжээ авч, элч илгээхээ больсны улмаас монголын дотоод байдлын талаар мэдээлэл багатай байсан. Иймээс 1479 оны 5 сарын мэдээ нь хэдэн сарын өмнө болсон хэрэг явдлыг тэмдэглэсэн байж болохыг анхаарах хэрэгтэй.

Исмаил тайши (1479-1486 он). Бэгэрсэн тайши алагдсаны дараа Исмаил тайши болж, түүнд эрх мэдэл төвлөрч зүүн Монголын гол нөлөө бүхий ноён болсон. Улмаар Мандуул хаан нас барсан нь Исмаилыг улам бүр хүчирхэгжүүлсэн нь тодорхой юм. Исмаил хэдэн онд тайши болсон төдийлөн тодорхойгүй бөгөөд 1479 онд тайшийн тушаалыг авсан бололтой. 1480 оноос Исмаины нэр хятад сурвалжид байнга тэмдэглэгдэх болсон. 1480 оны хаврын тэргүүн сард Исмаил Мин улсын Яньсүй рүү довтолж мингийн цэрэгтэй байлдсан талаар Мин улсын сударт “Исмаил (亦思馬因 yisimayin)-тай Яньсүйд байлдав” хэмээн тэмдэглээд “Вэйнин хайзыд Исмаилыг дайлж, ихэд дийлэв” хэмээжээ. 1481 оны зун Исмаил Сюаньфүд халдахад ...мингийн бүдүүлгүүдийг төвшитгөх жанжин түүнтэй тулалдсан ажээ⁷². Иймд 1480 онд Исмаил хэд хэдэн удаа Мин улсын умард хилийг халдан довтолсноос үзэхэд тэрээр нэлээд хүчирхэг байсан нь тодорхой бөгөөд тайшийн тушаалыг гүйцэтгэх болсныг илтгэж байгаа хэрэг юм. Исмаил тайши, Батмөнх даян хаан нар (түүний нэрийн өмнөөс Мандухай эцэн хатан төрийн эрхийг барьж байсан) хамтран монголыг нэгтгэх тэмцэлд нэлээд амжилт олж, Урианхайн гурван харуулын монголчуудыг дагуулсан ажээ. Энэ талаар Мин улсын сударт:

“Исмаил (亦思馬因 yisima'yin) улам улмаар олныг дуудан цуглуулж хил хязгаарыг дээрэмдэн тонож, улмаар Ляогийн хязгаарт хүрэв. Намар нь дайсны гурван түмэн морьт цэрэг Датуныг довтолж, цэргийн хүрээ 50 газар (li) үргэлжилж, хүн малыг алж хороон, дээрэмдсэн нь хэдэн түм болов”⁷³.

⁷⁰ 郑晓 (Zheng Xiao). 皇明北虏考 (Huangming Beilukao). 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 2006. 第一辑. 208 页.

⁷¹ 明實錄 (Ming shilu). 憲宗實錄 (Xianzong shilu). Чэнхуагийн 15-р оны 5 сарын цагаан морь өдөр

⁷² 明史 (Mingshi), 卷 14, 憲宗二, 176 頁.

⁷³ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8475

Ийнхүү нэгэн үе Исмаил ихээхэн хүчирхэг байсан боловч Хятад сурвалжид 1483 оноос Исмаилын нэр дурдагдахгүй болдог. Алтан ургийнхан болон алтан ургийн бус түшмэл, ноёдын зөрчил тэмцлийн улмаас монголчууд Мингийн хил хязгаарт халдан довтлох нь багассан бололтой. Энэ нь алтан ургийн бус ноёдын эрх мэдлийг хязгаарлах гэсэн хааны ордны бодлогоос үүдэлтэй ч байж мэднэ. Мин улсын судрын Татарын шастирт:

“Исмаил үхэж, түрэмгийлэгчид дахин бага хаан (小王子 xiaowangzi, сяованзы) хэмээн нэрлэж, бас Баянмөнх (伯顏猛可 boyang mungke, Батмөнх хааныг хэлж байна) ван (хаан) гэнэ. Хунжы (弘治 hongzhi)-ийн тэргүүн оны зун, бага хаан бичиг өргөн (奉書 fengshu) алба барихыг хүссэн (求貢 quigong) бөгөөд өөрийгөө Их Юань улсын их хаан (大元大可汗 dayuan dakehan) хэмээн нэрэлжихүй. Засгийн газар уужуу тайвнаар хандахыг хичээж үүнийг зөвшөөрөв. Тэр цагаас хойш Баянмөнх (Батмөнх) ван тэргүүнтэй хамт олонтаа алба барьж (入貢 rugong), Бортохой (套 tao)-д ирж очин, нэг гарч нэг үгүй болсоор хулгай дээрэм болов. 8-р онд умард аймгийн Ибрай ван тэргүүтэн Бор тохойд орж нутаглах болов. Тиймээс бага хаан болон Толоханы хөвгүүн Хошай нар харилцан түшилцэж өдөр ирэх тусам хүчирхэгжсээр зүүн баруун олон хязгаарын гай зовлон болов. Тэр жил, Сюаньфү, Датун, Яньсүй зэрэг олон хязгаар бүгд хэлмэгдэн хохиров”⁷⁴ хэмээсэн мэдээ байдаг.

Мин улсын сударт Исмаил тайши хэдэн онд нас барсан тодорхой тэмдэглээгүй. Гэвч сурвалжийн дээрх мэдээ он цагийг баримжаалах боломжийг олгож байна. “Исмаил үхэж, түрэмгийлэгчид дахин бага хаан (小王子 xiaowangzi, сяованзы) хэмээн нэрлэж” Жунжыгийн тэргүүн он буюу 1488 онд Монголын их хаан Батмөнх (хятад сурвалжид “бага хаан”) элч илгээн албан бичиг ирүүлсэн гэсэн мэдээг баримжаалж үзвэл Исмаил тайши 1488 оноос өмнө алагдсан нь тодорхой байна. Харин Мин улсын магад хуульд Хамийн вангийн мэдээлснээр 1486 онд Исмаилыг алагдсан хэмээн тэмдэглэсэн байдаг. Тиймээс Исмаил тайшийг 1486 онд алагдсан хэмээн үзэж болох юм. Нэгэн үе монголын төрийн гол институтийн үүргийг гүйцэтгэж байсан тайши тушаалыг хашсан сүүлчийн хүн нь Исмаил юм. “Батмөнх хаан Мандуул хааны дараа төрийн эрхийг гартаа оруулсан Исмаил тайшитай тэмцэлдэж “тайши” хэргэм тушаалыг устгажээ”⁷⁵.

Тайшийн институтийг устгасан нь

Монгол улсын их хаанаас тайши тушаалтныг албан ёсоор томилохоо больсон ч “тайши” цолыг зарим ноёд хэрэглэсээр байсан билээ. Монгол сурвалжид Юншээбүгийн Ибирай тайши хэмээн гардаг бөгөөд Мин улсын магад хуульд түүнийг тайши гэж тэмдэглээгүй. Батмөнх даян хаан дэд хүү Улсболдоор баруун гурван түмэнг захируулахаар илгээхэд Юншээбүгийн Ибарай тайши, Ордосын Мандулай ахлах нар “Бид дээрээ ноён авах хэрэг ману юун, өөрийн тэргүүнээ өөсөө мэдэж явах буй за” гэж Улсболдыг хороосон ажээ⁷⁶. Даян хаан их цэргээ удирдан

⁷⁴ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8475

⁷⁵ Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд* (XIV-XVI). УБ., 2022. т. 143.

⁷⁶ Сагансэцэн. *Эрдэнийн товч. Хөрвүүлэг, тайлбар хийсэн М.Баярсайхан*. УБ., 2015. т. 187-188

Далан тэргүүн нэрт газар байлдан ялалт байгуулсан. Ибарай тайши албат иргэдээ дагуулан Шар мөрнийг гатлан зугтаж, Лянжоу хүрч суужээ. Улмаар Хөх нуурт нэвтэрч, Түвэдэд халдан довтлох болсон. Барсболд жононгийн хүү Гүнбилэг жонон 1536 онд түүнийг бүрэн дарсан байдаг. Ийнхүү Ибарай тайши Хөх нуур, Лянжоу, Шар мөрний сав нутгийг нэгэн үе түйвээн хүчирхэг байснаас түүнийг албан ёсны тайши байсан хэмээн зарим судлаач үзэх нь буй. Мөн түүнчлэн Эсэнгийн хөвгүүд тайши цолыг үе залгамжлан хэрэглэж байсан билээ. Гэвч эдгээр нь зөвхөн өвөг дээдсийн тайши цолыг залгамжлан хэрэглэж байсан тохиолдол хэмээн үзэх нь зүйтэй юм. Исмаилаас хойш их хаан Батмөнх тайши тушаалтныг дахин томилоогүй нь тодорхой байна. Алтан ургийн бус ноёдын эрх мэдэл, сүр хүчийг хязгаарлаж, төрийн бүхий л эрх мэдлийг алтан урагт төвлөрүүлэх Батмөнх даян хааны бодлогын улмаас “тайши” албан тушаалтныг дахин томилсонгүй. Даян хааны үеэс түшмэдийн засаглалын эрх мэдэл хумигдаж, алтан ургийн засаглалд төрийн бүхий л эрх мэдэл шилжсэн эрх мэдлийн хуваарилалтын томоохон шилжилт болсон байдаг.

Тайши нь угсаа залгамжилдаггүй, томилогддог тушаал боловч тэрээр өөрийн түмнийхээ угсаа залгамжилсан ноён байдаг. Тайшийн удирдлага дор зүүн, баруун гарын чинсан зэрэг түшмэлүүд ажилладаг, цэрэг, иргэний асуудлыг хариуцдаг бие даасан институт байсан. Их хаан болон тайшийн цэрэг, улс төрийн нөлөө, хүчний тэнцвэр хэр байгаа нь тайшийн институт хүчирхэгжихэд чухал нөлөөтэй байв. Их хааны сүр хүч бууран доройтсон үед тайши нь хаанаас илүү эрх мэдэлтэй болж, төрийн засаглалын гол институт болж байв. Харин Батмөнх даян хаан засаглалын бүхий л эрх мэдлийг өөртөө авахын тулд түшмэдийн засаглалыг хүчийг сулруулах зорилгоор тайши тушаалтныг томилоогүй юм.

Жэн Сяогийн “Умард бүдүүлгийн шинжилгээ” (北虏考 beilukao)-д өгүүлснээр тайши нь маш их нэр хүндтэй албан тушаал байсан бөгөөд Батмөнх (зохиолд Баянмөнх гэж андуурсан П.Д.) багадаа хаан өргөмжлөгдөхөд тайши түүний эрх мэдлийг булаан авсан тул хожим тайшийн тушаалд хүн томилоогүй⁷⁷ хэмээн тайшийн институт байхгүй болсны шалтгааныг маш товч, тодорхой тайлбарласан ажээ.

Вэй Хуаны “Есөн хязгаарын шинжилгээ” (1541 он) сурвалжид:

“Хулгай нарын дунд хоригдож байгаад буцаж ирсэн хүмүүс ярих нь, бүдүүлэг хулгай (胡虏 hulu) хүчирхэг байх үед аймгууд *тайши* (太师 taishi) хэмээн их жанжины захиргаанд байсан. Тэрээр дэг журам тогтоож, олзонд шунахыг зорьдоггүй байв. *Тайшийн* албан тушаал байхгүй болж, жижиг эрх бүхий ноёдын (那颜 nayan) захиргаа тогтжээ. Улам бүр [тэдний] албат болж байна. Зөвхөн *тайжийн* (台吉 taiji) захиргаан дахь аймгууд тэдний албаас зайлсхийж чадах бөгөөд аймгууд *тайжийн* захиргаанд байхыг илүүд үздэг. *Тайж* нь хуучны хааны угсаа юм. *Тайжийг* эхийн хэвлийд байхад нь хүмүүс өөрсдийн эзэн болгохоор өрсөлддөг. Хэрэв эх нь төрвөл хүүхдийг өөрийн хүрээнд авчирна. Үүний үр дүнд, эдүгээ ихэнх аймгууд *тайжийн* захиргаанд оржээ. *Тайж* нар завхай, ёс журамгүй, шунахай. Тэдний хэлэхээр, бүдүүлгүүд бууран доройтох нь гарцаагүй”⁷⁸ хэмээн тэмдэглэсэн байдаг.

⁷⁷ 郑晓 (Zheng Xiao). 皇明北虏考 (Huangming Beilukao). 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 2006. 第一辑.

⁷⁸ 魏焕 (Weihuan). 九边考 (Jiubiankao). 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. Nei Menggu daxue chubanse. 2006. 244 页.

Дээрх сурвалжид монголчууд тайшийн засаглалаас алтан ургийн засаглалд шилжсэн тухай тодорхой мэдээлж байгаа нь үнэ цэнтэй юм. Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, тайшийн тушаал байхгүй болсноор тайж болон ноёдууд албат ардуудыг хуваан захирах болж, улам бүр бутран жижгэрч байгаа нь доройтлын үндсэн шалтгаан болохыг тодорхой илэрхийлсэн байна.

Түүнчлэн Е Сянгао-ын (1559-1627) “Дөрвөн бүдүүлгийн шинжилгээ” (四夷考 *siyikao*)-д монголчуудын “тайши бол цэргийн дээд жанжин”⁷⁹ хэмээсэн байдаг. Ийнхүү хятад сурвалжуудад монголчууд “хүчирхэг байх үед аймгууд *тайши* (太师 *taishi*) хэмээн их жанжины захиргаанд байсан”, “тайши бол цэргийн дээд жанжин” гэх зэргээр цэргийн жанжин гэдгийг онцолсон бичсэн байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Батмөнх даян хаан тайшийн институтийг устгаснаар түшмэдийн засаглалын тогтолцоо задарч, төрийн засаглалын бүхий л эрх мэдэл алтан урагт шилжжээ. Чухам энэ үеэс жононгийн засаглал хүчирхэгжиж, зүүн баруун гарт хуваан захирдаг хаан болон жонон гэсэн Алтан ургийн засаглалын тогтолцоо бүрэлдэн тогтож, бүрэн ялсан юм.

Дүгнэлт

XV зууны эхээр Монгол улсын дотоод улс төрийн зөрчил тэмцэл гүнзгийрч, их хааны сүр хүч бууран доройтсон нөхцөл байдал нь түшмэлийн засаглалын тэргүүлэх албан тушаал “тайши”-ийн институт хүчирхэгжих нөхцөлийг бүрдүүлсэн ажээ. Тайши нь Монголчуудын уламжлалт цол юм. Елюй Дашийн даши нь тайши гэсэн үг бөгөөд XII зууны монголчууд тайши цолыг авч хэрэглэсэн гэж үзэж байна. Нэг талаас легитим эрхтэй ч Монгол даяар засаглалаа хэрэгжүүлэх хүч нөлөөгүй “алтан ураг”-ийн хаан, нөгөө талаас цэрэг, улс төрийн хүч нөлөөтэй ч улс орныг засаглах легитим эрхгүй алтан ургийн бус ноён хоёрын эрх ашиг нэгдсэнээр “тайши”-ийн институт бүрэлдэн тогтсон. Тайши тушаалтан нь их хааны зарлигаар томилогдож байж легитим эрхтэй болдог байсан хэмээн үзэж байна. Шинэ хаан өргөмжлөхөд тайши гол үүрэгтэй байсан тохиолдол нэлээд олон. Нөгөө талаар хааныг өргөмжлөхөд гол үүрэг гүйцэтгэсэн ноён нь тэр хааныхаа зарлигаар тайшийн албан тушаалд томилогддог байжээ. Хоёр хаан зэрэг өргөмжлөгдсөн тохиолдолд хоёр тайши байх боломжтой гэсэн үг.

Тайшийн дор баруун, зүүн гарын чинсан тушаалтан болон бусад жижиг түшмэлүүд ажилладаг бүхэл бүтэн институт бүрэлдэн тогтсон. Тайши нь анхандаа хааны дэргэд цэргийн асуудлыг хариуцсан албан тушаал байсан бололтой. Албан бус хятад сурвалжуудад тайшийг цэргийн жанжин хэмээн бичдэг нь үүнтэй холбоотой байх. Улс орны цэргийн болон иргэний засаглалыг зааглах бодлогын улмаас цэргийн бүхий л хэргийг тайши хариуцаж байсан байж болох юм. Цэргийн эрх мэдлийг гартаа авсан тайши ихээхэн хүчирхэгжиж иргэний болон гадаад харилцаанд хүч нөлөөтэй, засаглалын хүчирхэг институт болж төлөвшсөн хэмээн үзэж байна.

⁷⁹ 叶向高 (Ye Xianggao). 四夷考 (Siyikao). 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 2006. 第二辑.

Нөгөө талаар тайши хэр эрх мэдэлтэй байх нь хааны хүч нөлөөнөөс хамааралтай буюу хүчний хуваарилалт, хүчний баланс хэр тэнцвэртэй байгаагаас хамаарч байжээ. Тайшийн институт нь улс орны цэргийн болон иргэний бүхий л хэргийг хамаарч байснаараа ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байсан гэж үзэж болно. Хааны эрх мэдэл, сүр хүч бууран доройтож, зарим үед их хааны эрх мэдэл үлэмж хязгаарлагдаж, тэр хэмжээгээр тайшийн институт хүчирхэгжиж байжээ.

Зөвхөн хаан болон тайшийн монголын төрд засаглахын төлөөх тэмцэл шийдвэрлэх үүрэгтэй байсан хэмээн үзэж болохгүй юм. Нөгөө талаар:

1. Их хаан ба түүнтэй өрсөлдөх алтан ургийн язгууртан

2. Тайши ба түүнтэй өрсөлдөх алтан ургийн бус ноёдын хоорондын тэмцэл нь монголын төрийн засаглалын тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлэх тохиолдлууд байв. Заримдаа алтан ургийнхны хоорондын хаан ширээний төлөө тэмцэл зөрчлийн гол эх сурвалж болж байсан. Гэвч яваандаа тайшийн төлөөх ноёдын тэмцэл зөрчлийн эх үүсвэр болох нь түгээмэл тохиолдол болсон ажээ. Энэ нь тухайн үеийн цэрэг улс төрийн хүчний хуваарилалт, хүчний баланстай холбоотой нь тодорхой юм.

“Алтан ураг”-ийн легитим эрхтэй хаан, цэрэг улс төрийн хамгийн хүчирхэг түмний ноён хоёрын хослол нь Монгол даяар засаглалаа хэрэгжүүлж, бусад түмнүүдээ захирах боломжтой нөхцөл байдлыг бүрдүүлдэг байжээ. Тайши нь угсаа залгамжилдаггүй, их хаанаас томилогддог албан тушаал тул эрх мэдлийн легитим байдал нь их хаанаас үүсэлтэй байв. Тиймээс XV зууны эхээс 1480-иад он хүртэлх Монголын төрийн засаглалд их хааны үүргийг үгүйсгэж, тайшийн үүргийг хэтрүүлэн үнэлэх нь нэг талаар зохимжгүй юм. Монголын “Их хаан” болон “тайши”-ийн институт хоёрын хооронд хэн нь засаглах асуудлаар хамгийн том өрсөлдөөн өрнөж байсан нь түүхэн үнэн. Гэвч засаглалын энэ хоёр институт бие биенээ үгүйсгэх аргагүй, харилцан хамааралтай институт болж төлөвшсөн хэмээн үзэж байна.

Abstract

Mongolian sources provide relatively little information about the Taishi, who played an important role in the governance of the Mongolia in the 15th century. By comparing Mongolian sources with Chinese sources, it is possible to clarify the role of the Taishi institution in Mongolian history. The deepening of internal political struggles in Mongolia and the weakening of the authority of the Great Khaan created the conditions for the strengthening of the official's government. The merging of the interests of the legitimate Khaan of the Chinggisid and the politically influential non-Chinggisid “Taishi” created the conditions for the formation of the “Taishi institution”. The interests of the Khaan and the Taishi were unified in order to govern Mongolia and to control other lords. Although the institutions of the Mongolian “Great Khaan” and “Taishi” competed with each other in governance issues, they are considered to have developed into mutually dependent institutions that cannot be denied.